

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12

- Конвенцид нэгдэн орох тухай Монгол Улсын хууль
- Дотоодын цэргийн тухай Монгол Улсын хууль
- Хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль
- Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль
- «Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хууль»-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР,
ХУУЛИЙН ТАЙЛВАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1995 оны 12-р сар № 12 /43/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | |
|---|------|
| 1. Конвенцид нэгдэн орох тухай | 1281 |
| 2. Дотоодын цэргийн тухай | 1281 |
| 3. Хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай | 1286 |
| 4. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1286 |
| 5. Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 1288 |
| 6. "Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1289 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | |
|---|------|
| 7. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндэв, түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг тогтоох тухай №41 | 1292 |
| 8. Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргыг томилох тухай №61 | 1295 |
| 9. Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүдийг томилох тухай №62 | 1295 |
| 10. Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлд адилтгах тухай №63 | 1296 |

11. Засгийн газрын танилцуулгыг хэлэлцсэн тухай №64	1296
12. Төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушвалын цалингийн болон албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай №65	1297
13. Цалингийн хэмжээ тогтоох тухай №66	1300
14. Монгол Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай №68	1303
15. Нэмж худалдах алт, мөнгөний хэмжээг тогтоох тухай №69	1304
16. Ерөнхийлөгчийн хоригийн тухай №70	1304
17. Ерөнхийлөгчийн хоригийн тухай №71	1305
18. Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүний цалин, хангамжийн тухай №72	1305
19. Төрийн захиргааны албан тушвалын зэрэг дэн, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай №73	1306

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

20. Шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай №127	1312
21. Шүүгчийг албан тушвалаас огцруулах тухай №128	1312
22. Шаравын Гунгвадоржийг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай №131	1313
23. Д. Бямбааг элчин сайдаар томилох тухай №132	1313
24. Дамбийнямын Жанчивыг Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор шагнах тухай №133	1314
25. Бандийн Гэлэгийг Монгол Улсын Спортын гавьяат дасгалжуулагч цолоор шагнах тухай №134	1314
26. Шүүгчийг албан тушвалаас чөлөөлж томилох тухай №141	1315
27. Рэнцэнгийн Цэрэндуламд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол олгох тухай №145	1315
28. Балдандоржийн Батхүүд Монгол Улсын гавьяат уурхайчин цол олгох тухай №146	1316
29. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх журмыг батлах тухай №151	1316
30. Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай №152	1319

**IV. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦ**

31. Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн маргааныг хянан шийдвэрлэсэн тухай №06 1320

**V. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

32. Ахмад дайчдад буцалтгүй тусламж олгох тухай №65 1325
33. Хэрэглэгчдэд түгээх эрчим хүч, усыг тоолуураар хэмжиж тооцох тухай №67 1325
34. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, идэвхжүүлэх зарим арга хэмжээний тухай №69 1327
35. Худалдааны албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай №72 1333
36. Соёл, урлаг хөгжүүлэх сангийн тухай №74 1334
37. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай №76 1338
38. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №78 1339
39. Ашигт малтмалын жагсаалт батлах тухай №81 1341
40. Зарим тостгоолыг хүчингүй болсонд тооцох тухай №83 1342
41. Тогтоол, тогтоолын зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай №86 1343
42. Буудайн сангийн дүрэм батлах тухай №88 1346
43. Сорьцны улсын хяналтын дүрэмд өөрчлөлт оруулах тухай №89 1348
44. Хөдөлмөрийн хөлсний жишиг, журам батлах тухай №90 1350
45. Зарим сургуулийг нэрэмжит болгох тухай №91 1353
46. Гурилд ногдуулах гаалийн албан татварыг хөнгөлөх тухай №92 1354
47. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай №94 1355

48. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг батлах тухай №95 1365

ҮІ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

49. Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7-р зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай №246 1369

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

"Озоны үе давхаргыг хамгаалах тухай" Венийн 1985 оны конвенци, 1991 оны 6 дугаар сарын 27-29-нд Лондонд, 1991 оны 6 дугаар сарын 19-21-нд Найробид, 1992 оны 11 дүгээр сарын 23-25-нд Копенгагенд болсон талуудын зөвлөлгөөнөөр засвар, залруулга, нэмэлт, өөрчлөлт оруулсан "Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай" Монреалийн 1987 оны протоколд тус тус нэгдэн орсугай.

Монгол Улсын Их
Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын дотоодын цэргийн /цаашид "дотоодын цэрэг" гэх/ тогтолцоо, үйл ажиллагааны нь эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Дотоодын цэргийн тухай
хууль тогтоомж

Дотоодын цэргийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдалын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, энэ

хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Дотоодын цэргийн үйл
ажиллагааны зарчим

1. Дотоодын цэрэг нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах зарчим баримтална.

2. Дотоодын цэргийн бүх шатны байгууллагыг эрх бүхий дээд шатны байгууллагаас томилсон захирагч /дарга/ удирдана.

4 дүгээр зүйл. Дотоодын цэргийг удирдах талаар
Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар нь Дотоодын цэргийг удирдах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ дотоодын цэргийн даргыг томилох, чөлөөлөх;

2/ дотоодын цэргийн ангийг байгуулах, татах буулгах;

3/ дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмийг батлах;

4/ дотоодын цэргийн зарим алба хаагчид олгох албаны нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу тогтоох;

5/ онц чухал объектын жагсаалтыг батлах;

6/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5 дугаар зүйл. Дотоодын цэргийн бүтэц,
удирдлага

1. Дотоодын цэрэг нь дотоодын цэргийн штаб, мэргэжлийн анги, байгууллагаас бүрдэнэ.

2. Монгол Улсын цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн дарга байна.

6 дугаар зүйл. Дотоодын цэргийн даргын
бүрэн эрх

Дотоодын цэргийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ дотоодын цэргийн үйл ажиллагааг удирдах;

2/ дотоодын цэргийн анги, байгууллагын үүргийг тогтоож, удирдамжийг батлах;

3/ дотоодын цэргийг бүхэлд нь болон тодорхой анги, байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх, өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах шийдвэр гаргах;

4/ цэрэг татах, халах талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжид заасан үндэслэлээр дотоодын цэргийн алба хаагчийг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, халах, бэлтгэл үүрэгтнийг чөлөөнд гаргаж бүртгэлээс хасах;

5/ дотоодын цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, нөхөн хангах ажлыг зохион байгуулах;

6/ дотоодын цэргийг бие бүрэлдэхүүн, зэвсэг техник, материал хэрэгслээр нөхөн хангах ажлыг удирдан зохион байгуулах.

7 дугаар зүйл. Дотоодын цэргийн штаб

1. Штаб нь дотоодын цэргийг удирдах байгууллага мөн.

2. Штаб нь дотоодын цэргийн даргын удирдлагад ажиллана.

3. Дотоодын цэргийн штабын даргыг дотоодын цэргийн дарга томилно.

8 дугаар зүйл. Дотоодын цэргийн санхүүжилт,
материал техникийн хангамж,
зэвсэглэмж

1. Дотоодын цэрэг нь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжинэ.

2. Дотоодын цэргийн аж ахуй, материал-техникийн хангалтыг Цагдаагийн төв байгууллага хариуцна.

3. Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ дараахь зэвсэг болон тусгай хэрэгсэл, мэх ашиглана:

1/ галт зэвсэг;

2/ нэг бүрийн тусгай хэрэгсэл;

3/ тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;

4/ хамгаалах тусгай хэрэгсэл;

5/ албаны нохой;

6/ зэвсэггүйгээр тулалдах мэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дотоодын цэргийн зорилт, чиг үүрэг, эрх

9 дүгээр зүйл. Дотоодын цэргийн зорилт,
үндсэн чиг үүрэг

1. Дотоодын цэргийн зорилт нь улсын онц чухал объектыг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргийг таслан зогсооход оролцох болон хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлэхэд эршино.

2. Дотоодын цэрэг дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлднэ:

1/ улсын онц чухал объектыг хамгаалах;

2/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах ажилд болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох;

3/ шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх;

3. Дотоодын цэргийн албаны үйл ажиллагааг алба-ажиллаганы дүрмээр зохицуулна.

10 дугаар зүйл. Дотоодын цэрэг нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргийг таслан зогсооход оролцох талаархи чиг үүрэг

1. Цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй үед тэнд туслах зорилгоор дотоодын цэрэг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ баяр ивадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийгмийн хэв журмыг сахиулахад туслах;

2/ гудамж, талбай зэрэг олон нийтийн газар нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед иргэдийн болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалахад туслах;

3/ гнидан, хугацаагүй хорих тусгай салбар, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтооход оролцох;

4/ оргон нуугдсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох;

5/ их хэмжээний үнэт зүйл, мөнгөн тэмдэгтийг зөөж тээвэрлэх үеийн хамгаалалтын ажилд туслах.

2. Нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаанд оролцох төлөвлөгөө, удирдамжийг дотоодын цэргийн дарга батална.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үед дотоодын цэрэгт галт зэвсэг тавьж олгохыг хориглоно.

11 дүгээр зүйл. Дотоодын цэрэг дайн бүхий болон дайны байдал, онц байдлын үед ажиллах

Дотоодын цэрэг нь дайн бүхий болон дайны байдал, онц байдлын үед ажиллах журмыг дайн бүхий болон дайны байдлын тухай, онц байдлын тухай хууль тогтоомжоор тогтооно.

12 дугаар зүйл. Дотоодын цэргийн эрх

1. Дотоодын цэргийн анги, байгууллага, албан хаагч үүргээ биелүүлэхдээ дараахь эрх эдэлнэ:

1/ дотоодын цэрэг нь объектыг хамгаалах, хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцохдоо хамгаалалтад байгаа объектод нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх бичгийг шалгах, ачаа тээшинд үзлэг хийх;

2/ энэ хуулийн 9, 10 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ иргэдэд шаардлага тавих, зөрчлийг таслан зогсоох, гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

3/ хамгаалж байгаа объектод халдсан, нууцаар нэвтрэн орохыг оролдсон этгээдийг саатуулж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

2. Дотоодын цэрэг нь энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 4, 5-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үед зөвсөг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн холбогдох заалтыг баримтална.

3. Дотоодын цэрэг нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Дотоодын цэргийн алба хаагч, түүний эрх зүйн баталгаа

13 дугаар зүйл. Дотоодын цэргийн алба хаагч

Монгол Улсын цэргийн таигарагийг өргөж, дотоодын цэргийн аль нэг байгууллагад алба хааж, суралцаж байгаа Монгол Улсын иргэнийг дотоодын цэргийн алба хаагч гэнэ.

14 дүгээр зүйл. Дотоодын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал

1. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа дотоодын цэргийн алба хаагчид Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулиар цагдаагийн алба хаагчдад олгосон баталгаа нэг адил хамаарна.

2. Дотоодын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын зөвсөгт хүчний дагаж мөрддөг хууль тогтоомж, цэргийн дүрмүүдээр зохицуулна.

3. Дотоодын цэргийн алба хаагчид Монгол Улсын Брөнхийлөгчийн зарлигаар батлагдсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ. Хуульд зааснаас бусад тохиолдолд Дотоодын цэргийн дүрэмт хувцастай ижил загварын дүрэмт болон ажлын хувцас өөр байгууллагад хэрэглэхийг хориглоно.

4. Дотоодын цэргийн алба хаагчдын ажилласан хугацааг тооцоход гяндан, хугацаагүй хорих салбар, онцгой, чанга дэглэмтэй хорих ангийн болон тев суурин газраас авслагдсан газрын объектын харуул хамгвалалтвд ажилласан 1 жилийг 1 жил 2 сараар тооцно.

15 дугаар зүйл. Дотоодын цэргийн алба хаагчдад
хүлээлтгэх хариуцлага

Монгол Улсын хууль тогтоомж, өргөсөн тангараг, цэргийн дүрмүүдийн заалтыг зөрчсөн дотоодын цэргийн алба хаагчид эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын Их
Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХУЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Монгол Улсын дотоодын цэргийн тухай хууль" хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн "Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай" хуулийн долдугаар бүлэг /49, 50 дугаар зүйл/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их
Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн гарчиг,

мөн зүйлийн 2, 3 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн гарчиг, 2, 3 дахь хэсэг:

"9 дүгээр зүйл. Шүүгчийн тангараг, шүүхийн бэлгэ тэмдэг, шүүгчийн өмсгөл

2. Шүүх бэлгэ тэмдэгтэй, шүүгч өмсгөлтэй байна.

3. Шүүгчийн тангараг өргөх журам, шүүхийн бэлгэ тэмдэг, шүүгчийн өмсгөлийн загвар, тэдгээрийн хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална."

2/64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Шүүгчийн цалин хөлс нь шүүгчийн албан тушаалын цалин болон шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.

Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлүүдийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

Улсын дээд шүүхийн шүүгч төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон албан тушаалын цалин авна.

Бусад шүүгчийн цалинг Улсын дээд шүүхийн шүүгчийн цалинтай зохист харьцаатай байхвар тооцож тогтооно. Шүүгчид Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан сахилгын шийтгэл ногдуулсан, шүүгчийн бүрэн эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу түдгэлзүүлснээс бусад тохиолдолд түүний цалинг бууруулж болохгүй."

2 дугаар зүйл. Шүүхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 8 дугаар зүйлийн 5 дахь заалт, 25 дүгээр зүйл тус тус нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 5 дахь заалт:

"5. Энэ зүйлийн 4 дэх заалт нь Улсын дээд шүүхийн хинаалтын шүүх хуралдаанд хамарахгүй."

2/25 дүгээр зүйл. Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн бүрэн эрх

1. Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч шүүгчийн бүрэн эрхээс гадна дарваах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ энэ хуулийн 6 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан тохиолдолд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг орлох;

2/ танхимыг тэргүүлж танхимын шүүгчид, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлыг удирдан зохицуулах;

3/ танхимын шүүх хуралдааныг даргалах, эсхүл шүүх хуралдааны даргалагч, оролцогч, илтгэгчээр шүүгчдийг томилох;

4/ танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр шүүх,

шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

5/ танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

6/ танхимын эрхэлсэн шүүн таслах ажлын чиглэлээр хэргийн харьяалал тогтоох;

7/ хууль, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын талаар шүүгчийн мэргэшлийн хороогоор дүгнэлт гаргуулахаар хүсэлт тавих;

8/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

2. Танхимын тэргүүн шүүгч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7-д заасан асуудлаар захирамж гаргана."

3 дугаар зүйл. Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхий шүүгч" гэсэн үгийн дараа "танхимын тэргүүн шүүгч" гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их
Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 9, 10 дахь заалт нэмсүгэй:

<<9/мөрийтэй тоглоом тоглуулах, казино ажиллуулах журмын биелэлтэд хяналт тавих;

10/ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж байгаа өнгөт хувилагчийг бүртгэж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих.>>

Монгол Улсын Их
Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

<<МОНГОЛ УЛСЫН 1995 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ>>-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн /цаашид энэ хуульд <<1995 оны төсвийн тухай хууль>> гэх/ 1 дүгээр зүйлд заасан 1995 оны улсын төвлөрсөн төсвийн зарим нэр төрлийн орлогын дүнг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй.

	/минган төгрөг/
Улсын төвлөрсөн төсвийн орлого бүгд	20709876,3
1. Албан татварын орлого	13256791,6
1/ орлогын албан татвар	8750040,5
2/ гаалийн албан татвар	924649,2
3/ худалдааны албан татвар	1050811,6
5/ бусад татвар	435900,0
6/ нийгмийн даатгалын шимтгэл	700418,0
8/ автобензин, дизелийн түлшний албан татвар	1394972,3
2. Татварын бус орлого	7053084,7
1/ хувьцааны ногдол ашиг	3915987,2
2/ бусад орлого	3100583,2
3/ төсөвт байгууллагын өөрийн орлого	36514,3
3. Хөрөнгийн орлого	400000,0
1/ Өмч хувьчлалын сангийн орлого	400000,0

2 дугаар зүйл. 1995 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан улсын төвлөрсөн төсвийн зарим нэр төрлийн орлогын дүнг дор дурдсанаар хорогдуулсугай:

Улсын төвлөрсөн төсвийн орлого-бүгд	2356677,0
1. Албан татварын орлого	2356677,0
4/ онцгой албан татвар	961704,7

7/ замын сангийн орлого 1394972,3
 3 дугаар зүйл. 1995 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан төсвийн зарлагын хэмжээг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

Улсын төвлөрсөн төсвийн зарлага-бүгд	18353199,3
1/ цалингийн сан	1214342,1
2/ хөрөнгө оруулалт	6246000,0
Үүнээс: Шинээр эхлэх барилга, объектын нийт өртөг	
Үүний дотор 1995 онд санхүүжүүлэх хэмжээ	4299000,0
3/ нийгмийн ерөнхий үйлчилгээний зардал	15943,1
4/ батлан хамгаалах арга хэмжээний зардал	288198,4
5/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсөв	248,2
6/ Монгол Улсын Их Хурлын төсөв	13005,5
7/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	249,5
8/ Шүүхийн төсөв	60224,5
9/ Прокурорын төсөв	27021,7
10/ Тагнуулын төв газрын төсөв	23720,8
11/ Тэтгэврийн даатгалын санд олгох татаас	1352191,3
Үүнээс-нөөц бий болгоход	500000,0
12/ аймгийн төсөвт өгөх татаас	3091494,0

4 дүгээр зүйл. 1995 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан аймгийн төсөвт өгөх татаасны хэмжээг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

Архангай	163340,0
Баян-Өлгий	96940,0
Баянхонгор	193740,0
Булган	85440,0
Говь-Алтай	144196,0
Дорноговь	81680,0
Дорнод	286753,0
Дундговь	88040,0
Завхан	169758,0
Өвөрхангай	165460,0
Өмнөговь	115416,0
Сүхбаатар	103578,0
Сэлэнгэ	167078,0
Увс	296607,0
Ховд	166080,0
Хөвсгөл	154971,0
Хэнтий	149782,0

5 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс дараах аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар хуваарилан тогтоосугай:

Төв	366285,0
Дархан-Уул	78250,0
Говь-Сүмбэр	18100,0

6 дугаар зүйл. 1995 онд олборлох алтын хэмжээг тогтоосон Монгол Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 87 дугаар тогтоолд завсан хэмжээнээс нэмэгдүүлэн Монголросцветмет нэгдлийн олборлох алтанд ногдох нөөцийн төлбөр болон худалдааны албан татварын орлогыг энэ ойм тухайд улсын төвлөрсөн төсөвт оруулахаар тогтоосугай.

Монгол Улсын Их
Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

**Төрийн өндөр албан тушаалтны
зэрэг дэвд хамаарах төрийн
албан тушаалын зэрэг зиндаа,
түүнтэй адилтгах албан тушаалын
зэрэглэлийг тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа болон түүнтэй адилтгах албан тушаалын зэрэглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаатай болон яамд, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлтэй адилтгах улс төрийн болон төрийн тусгай албан тушаалын зэрэглэл тогтоохыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ДЭВД
ХАМААРАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН
ЗЭРЭГ ЗИНДАА**

Зэрэг зиндав	Улс төрийн албан тушаал	Захиргааны албан тушаал	Тусгай албан тушаал
ТӨ-I	Монгол Улсын Ерөнхийлөгч		
ТӨ-II	Монгол Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхий сайд		
ТӨ-III	Монгол Улсын Их Хурлын дэд дарга		Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга
ТӨ-IV	Монгол Улсын Их Хурлын ги- шүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Монгол Улсын сайд		
ТӨ-V			Монгол Улсын Ерөнхий проку- рор
ТӨ-VI			Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Монгол Улсын дээд шүүхийн шүүгч

**ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ДЭВД
ХАМААРАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ
ЗИНДААТАЙ АДИЛТГАХ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ**

Адилтгах албан тушаалын зэрэглэл	Улс төрийн албан тушаал	Захиргааны албан тушаал	Тусгай албан тушаал
ТӨ-ҮА	Нийслэлийн захирагч		
ТӨ-ҮА	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний аюулгүй байд- лын зөвлөлийн нарийн бичгийн дарга Аймгийн Засаг дарга	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Төрийн захир- гааны албаны зөвлөлийн дарга	Төрийн хя- нан шалгах хорооны дарга, Монголбанхны Ерөнхийлөгч, Үнэт цаасны хорооны дарга
ТӨ-ҮА	Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газрын дарга Дэд сайд Ерөнхийлөгчийн зөвлөх	Шүүхийн ерөн- хий зөвлөлийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын дэд бүтцэд ордог тусгай газрын дарга	Монголбанхны дэд ерөнхий- лөгч, Улсын Ерөнхий прокурорын орлогч Төрийн хянан шалгах хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны албаны
зөвлөлийн даргын томилох тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 7 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаас Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал болгосныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Ламжавиц Линговьг Монгол Улсын Төрийн захиргааны албаны зөвлөлийн даргаар томилсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны албаны зөвлөлийн
орон тооны гишүүдийг томилх тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс дэвшүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр Халтарын Шаандар, Ламжавиц Лингов, Намжилдоогийн Чадралбал нарыг томилсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны албан тушаалын
зэрэглэлд адилтгах тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгийн ажлын албаны орон
тооны ажилтныг төрийн захиргааны албан тушаалын хүрээнд гүй-
цэтгэх албан тушаалтантай адилтган үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

**Засгийн газрын танилцуулгыг
хэлэлцсэн тухай**

"Зарим гэрээ, хэлцлийн тухай" Монгол Улсын Үндэсний аюулгүй
байдлын зөвлөлийн 1995 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 05 дугаар
зөвлөмжийн дагуу Засгийн газраас авсан арга хэмжээ, танихмын
хуралдаангаар хэлэлцээд гаргасан дүгнэлтийн тухай Монгол Улсын
Ерөнхий сайд П. Жасрайн танилцуулга, Улсын Их Хурлын Төрийн
байгуулалтын байнгын хорооны дүгнэлт, саналыг хэлэлцээд **ТОГ-
ТООХ** нь:

1. Засгийн газарт даалгах нь:

1/ Монгол Улсын олон улсын гэрээний тухай хууль тогтоомжийг
хэрэгжүүлэхэд гарч байгаа доголдол, дутагдалд дүгнэлт хийж,
түүнийг арилгах, олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах,

хэрэгжүүлэхэд тавих хяналт, шаардлагыг бүх шатанд сайжруулах, энэ талаар Засгийн газрын гишүүд, холбогдох удирдах ажилтан албан тушаалтны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, алдаа, дутагдал гаргасан хүмүүст хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж байх;

2/ гадаадын хөрөнгө оруулахтай холбогдсон гэрээ, хэлцлүүд Монгол улсын хууль тогтоомж, Монгол Улсын ашиг сонирхолд хэрхэн нийцэж байгааг хянан үзэж, энэ онд багтаан Улсын Их Хуралд мэдээлэх.

2. Энэ тогтоолын биелэлтэд болон Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрт байнгын хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд үүрэг болгосугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот
Дугаар 65

Төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн болон албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 28 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 80 мянган төгрөгөөр, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын даргын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 60 мянган төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд зааснаас бусад төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн сарын цалингийн хэмжээг хавсралтын ёсоор баталсугай.

3. Монголбанкны Ерөнхийлөгч, Төрийн хянан шалгах хорооны дарга, Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга, Үнэт цаасны хорооны даргын сарын цалингийн хэмжээг 40 мянган төгрөгөөр тогтоосугай.

4. Үндсэн хуулийн цэцийн даргын сарын цалинг 46 мянган төгрөгөөр, Сонгуулийн ерөнхий хорооны даргын сарын цалинг 38 мянган төгрөгөөр, Үндсэн хуулийн цэцийн орон тооны гишүүний сарын цалинг 40 мянган төгрөгөөр тогтоосугай.

5. Энэ тогтоолыг дагуу шинэчлэн тогтоосон албан тушаалын цалинг 1995 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн олгохоор тогтоосугай.

6. Энэ тогтоолыг хавсралтад болон 3,4 дүгээр зүйл /Монгол Улсын шадар сайдаас бусад/-д дурдсан улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг хууль тогтоомжоор тусгайлан тогтоосноос бусад тохиолдолд албан тушаалын сарын цалингийнх нь 10 хувиар тогтоож, 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгосугай.

7. Монгол Улсын шадар сайдын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг 15 хувиар тогтоож, 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн олгосугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 7
дугаар сарын 4-ний өдрийн 65 дугаар
тогтоолын хавсралт

**ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ
ЗАРИМ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН
САРЫН ЦАЛИН**

	цалингийн хэмжээ /төгрөгөөр/
Монгол Улсын Их Хурлын дэд дарга	46000
Монгол Улсын Их Хурлын гишүүн	44000
Монгол Улсын Засгийн газрын гишүүн шадар сайд, сайд	44000
Нийслэлийн Засаг дарга	44000
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	40000
Монгол Улсын ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга	40000
Аймгийн Засаг дарга	40000
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх	38000
Дэд сайд	38000
Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог тусгай газрын дарга	38000
Дүүргийн засаг дарга	27000
сумын Засаг дарга	25000
Хорооны Засаг дарга	21000
Багийн Засаг дарга	20000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Цалингийн хэмжээ
тогтоох тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 28 дугаар зүйлийн
4 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн шүүгчдийн албан тушаалын сарын ца-
линыг нэгдүгээр хавсралт, Монгол Улсын прокурорын албан тушаал-
ын сарын цалиныг хоёрдугаар хавсралтын дагуу тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай хөлбөгдүүлэн "Шүүгчийн цалин тог-
тоох тухай", "Монгол Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын
10-ны өдрийн 07 дугаар тогтоол", "Прокурорын цалин тогтоох
тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын 10-ны
өдрийн 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 1995 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж
мөрдсүгэй.

Дарга

Н. БАГАВАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1995
оны 7 дугаар сарын 4-ний өдрийн
66 дугаар тогтоолын I хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮГЧДИЙН АЛБАН ТУШААЛЫН
САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Сарын цалин /төгрөгөөр/
1.	Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	46000
2.	Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч	42000
3.	Улсын Дээд шүүхийн шүүгч	40000
4.	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	38000
5.	Нийслэлийн шүүхийн шүүгч	34000
6.	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	35000
7.	Аймгийн шүүхийн шүүгч	30500
8.	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	30000
9.	Дүүргийн шүүхийн шүүгч	27500
10.	Сум болон сум дундын шүүхийн ерөнхий шүүгч	27000
11.	Сум болон сум дундын шүүхийн шүүгч	25000

Монгол Улсын Их Хурлын 1995
оны 7 дугаар сарын 4-ний өдрийн
66 дугаар тогтоолын II хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН
САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Сарын цалин /төгрөгөөр/
1.	Ерөнхий прокурор	42000
2.	Ерөнхий прокурорын орлогч	40000
3.	Ерөнхий прокурорын газрын туслах прокурор	38000
4.	Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	33000
5.	Нийслэлийн прокурор	36500
6.	Нийслэлийн прокурорын орлогч	34000
7.	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	32000
8.	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	28000
9.	Дүүргийн ахлах прокурор	28500
10.	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	26000
11.	Аймаг, тээврийн прокурор	33500
12.	Аймаг, тээврийн прокурорын орлогч	31500
13.	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	30000
14.	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	28000
15.	Сум болон сум дундын ахлах прокурор	25500
16.	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	24000

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын 1995 оны
намрын чуулганаар хэлэлцэх асуудлын
тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулганаар дор дурдсан асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай:

1. Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
2. Коррупцийн эсрэг тэмцэх тухай хууль;
3. Гүйцэтгэх ажлын тухай хууль;
4. Дотоодын цэргийн тухай хууль;
5. Зээл хадгаламж, төлбөр тооцооны хууль;
6. Векселийн хууль;
7. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
8. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль;
9. Онц байдлын тухай хууль;
10. Төрийн дээд шагналын тухай хууль;
11. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 1996 оны үндсэн чиглэл;
12. Монгол Улсын 1996 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хууль;
13. Монгол Улсын төрөөс 1996 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл;
14. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
15. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай хууль;
16. Нийгмийн бодлогын тухай багц хууль;
17. Татвар, төлбөрийн тухай хуулиуд;
18. Үндэсний хөгжлийн үзэл баримтлал;
19. Хорихоос өөр төрлийн ял оногдуулах тухай хууль;
20. Гадаад худалдааны арбитрын тухай хууль;
21. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль;

22. Бусад асуудал.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 10 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Нэмж худалдах алт, мөнгөний
хэмжээг тогтоох тухай

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эрдэнэсийн гүйлгээний сангаас 1995 онд аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд худалдах алтыг 20,0 /хорин/ кг, мөнгийг 300,0 /гурван зуу/ килограммаар нэмэгдүүлсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс "Төрийн өндөр албан тушаалтмын зэрэг дээд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаа, төрийн өндөр албан тушаалтмын зэрэг дээд хамаарах төрийн албан тушаалын зэрэг зиндаатай адилтгах албан тушаалын зэрэглэл"-ийг тогтоох тухай Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 03-ны эдрийн

41 дүгээр тогтоолд тавьсан хоригийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын 1995 оны 41 дүгээр тогтоол нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчөөгүй тул Ерөнхийлөгчийн 1995 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 49 тоот хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын болон албан ажлын онцгой нөхцөлийн нэгмэгдлийн хэмжээг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 1995 оны 65 дугаар тогтоолын нэгдүгээр зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хэлэлцээд **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 65 дугаар тогтоолын нэгдүгээр зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны албан тасвэдийн
орон тооны гишүүний цалин, хангамжийн
тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг "Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэгдэл"-ийн "тэргүүн түшмэл" гэсэн ангиллын "ТЗ-12"-д хамааруулан цалингийн хэмжээ, хангамжийг тогтоосугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Төрийн захиргааны албан тушаалын
зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох
журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхийг даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1995 оны
73 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН
ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ
ОЛГОХ ЖУРАМ**

1. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 7,20 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны албан тушаал нь дор дурдсан зэрэг дэвтэй байна:

Түшмэлийн албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв
Тэргүүн түшмэл	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл Дэд зэрэг тэргүүн түшмэл Гутгаар зэрэг тэргүүн түшмэл Дөтгөөр зэрэг тэргүүн түшмэл
Эрхэлсэн түшмэл	Тэргүүн зэрэг эрхэлсэн түшмэл Дэд зэрэг эрхэлсэн түшмэл Гутгаар зэрэг эрхэлсэн түшмэл Дөтгөөр зэрэг эрхэлсэн түшмэл
Ахлах түшмэл	Тэргүүн зэрэг ахлах түшмэл Дэд зэрэг ахлах түшмэл Гутгаар зэрэг ахлах түшмэл Дөтгөөр зэрэг ахлах түшмэл
Дэс түшмэл	Тэргүүн зэрэг дэс түшмэл Дэд зэрэг дэс түшмэл Гутгаар зэрэг дэс түшмэл Дөтгөөр зэрэг дэс түшмэл
Туслах түшмэл	Тэргүүн зэрэг туслах түшмэл Дэд зэрэг туслах түшмэл Гутгаар зэрэг туслах түшмэл Дөтгөөр зэрэг туслах түшмэл

2. Тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг яам, төрийн бусад албан газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхий сайд тус тус олгоно. Ийнхүү тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дээ олгох саналыг эрх бүхий албан тушаалтанд өргөн мэдүүлэхдээ төрийн захиргааны албаны зөвлөлийн саналыг авсан байна.

3. Монгол улсын яам, тусгай газар, түүнчлэн эрхлэх үйл ажиллагааных нь хүрээнд хамаарах болон тэргүүлэн удирдаж буй яам, газрынх нь шууд харьяа төрийн байгууллагуудад ажиллаж буй ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог газруудын дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Үнэт цаасны хорооны дарга, Төрийн хянан шалгах хорооны дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

4. Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дээ олгохдоо төрийн захиргааны албанд нийт ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэнэ.

5. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлтэй дараахь байдлаар зохицолдуулж олгоно:

Албан тушаалын зэрэг дээ	Албан тушаалын зэрэглэл
Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл Дэд зэрэг тэргүүн түшмэл Гутгаар зэрэг тэргүүн түшмэл Дөтгөөр зэрэг тэргүүн түшмэл	T3-13 T3-12
Тэргүүн зэрэг эрхэлсэн түшмэл Дэд зэрэг эрхэлсэн түшмэл Гутгаар зэрэг эрхэлсэн түшмэл Дөтгөөр зэрэг эрхэлсэн түшмэл	T3-11 T3-10

Тэргүүн зэрэг ахлах түшмэл Дэд зэрэг ахлах түшмэл Гутгаар зэрэг ахлах түшмэл Дөтгөөр зэрэг ахлах түшмэл	ТЗ-9 ТЗ-8 ТЗ-7
Тэргүүн зэрэг дэс түшмэл Дэд зэрэг дэс түшмэл Гутгаар зэрэг дэс түшмэл Дөтгөөр зэрэг дэс түшмэл	ТЗ-6 ТЗ-5 ТЗ-4
Тэргүүн зэрэг туслах түшмэл Дэд зэрэг туслах түшмэл Гутгаар зэрэг туслах түшмэл Дөтгөөр зэрэг туслах түшмэл	ТЗ-3 ТЗ-2 ТЗ-1

6. Зэрэг дэвийг төрийн албанд нийт ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацааг харгалзан олгоно. Үүнд:

Албан тушаалын зэрэг дэв	Албан тушаалын ангилал	ЭХЛЭЛСЭН ҮҮШМЭЛ ХУВИЙН МЭДЭЭ	
		Төрийн албанд	Туслах албан тушаалын ангилалд
<ul style="list-style-type: none"> Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл Дэд зэрэг тэргүүн түшмэл Гутгаар зэрэг тэргүүн түшмэл Дөтгөөр зэрэг тэргүүн түшмэл 	Тэргүүн түшмэл	19-өөс доошгүй жил	
<ul style="list-style-type: none"> Тэргүүн зэрэг эрхэлсэн түшмэл Дэд зэрэг эрхэлсэн түшмэл Гутгаар зэрэг эрхэлсэн түшмэл Дөтгөөр зэрэг эрхэлсэн түшмэл 	Эрхэлсэн түшмэл	17-өөс доошгүй жил	1
<ul style="list-style-type: none"> Тэргүүн зэрэг ахлах түшмэл Дэд зэрэг ахлах түшмэл Гутгаар зэрэг ахлах түшмэл Дөтгөөр зэрэг ахлах түшмэл 	Ахлах түшмэл	14-өөс доошгүй жил	2
<ul style="list-style-type: none"> Тэргүүн зэрэг дэс түшмэл Дэд зэрэг дэс түшмэл Гутгаар зэрэг дэс түшмэл Дөтгөөр зэрэг дэс түшмэл 	Дэс түшмэл	10-аас доошгүй жил	2
<ul style="list-style-type: none"> Тэргүүн зэрэг туслах түшмэл Дэд зэрэг туслах түшмэл Гутгаар зэрэг туслах түшмэл Дөтгөөр зэрэг туслах түшмэл 	Туслах түшмэл	5-аас доошгүй жил	3

7. Төрийн албанд нийт ажилласан хугацаанд төрийн бүх төрлийн албан тушаалд ажилласан хугацааг оруулж тооцно.

8. Зэрэг дэв олгох хугацаа болсон бөгөөд уул зэрэг дэв нь төрийн захиргааны албан хаагчийн тухайн албан тушаалд тохирч байгаа боловч түүний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин нь хангалтгүй байвал уг зэрэг дэвийг олгохгүй байж болно.

9. Төрийн захиргааны зэрэг дэв бүхий албан хаагчид сар бүр түүний албан тушаалын сарын цалингаас дор дурдсан хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл олгоно:

Албан тушаалын ангилал	Зэрэг дэвийн нэмэгдэл хувиар			
	тэргүүн	дэд	гутгаар	дотгоо
Тэргүүн түшмэл	25	20	15	10
Эрхэлсэн түшмэл	25	20	15	10
Ахлах түшмэл	25	20	15	10
Дэс түшмэл	25	20	15	10
Туслах түшмэл	25	20	15	10

10. Төрийн захиргааны ажилд нарийн мэргэшин онцгой үр бүтээлтэй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид энэ журмын 6 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө зэрэг дэв олгож болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл зэрэг дэвийг алгасуулан олгож болно.

11. Өөрөө хүсэлт гаргасан, өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн захиргааны бус өөр ажил, албан тушаалд томилсон буюу сонгосон, биеийн эрүүд мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн захиргааны албан хаагч төрийн захиргааны албан тушаалд 3 жилийн дотор дахин томилогдвол урьд олгогдсон зэрэг дэвээ хэвээр эдэлнэ.

12. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсноор буюу сахилгын шийтгэл хүлээж төрийн албанаас халагдсан төрийн захиргааны албан хаагчид олгосон зэрэг дэв нь түүнийг ажлаас халсан өдрөөс эхлэн хүчингүйд тооцогдоно.

13. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1-ийн 1,2-т заасан сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд эрхэлсэн албан тушаалдаа тэнцэхгүй тохиолдолд төрийн захиргааны албан

хаагчид олгосон зэрэг дэвийг бууруулж болно. Харин мэргэшлийн түвшингийн хувьд тэнцэж байгаа албан тушаалын ангиллаас доогуур албан тушаалд өөрийн хүсэлтээр болон ажлын зайлшгүй шаардлагаар шилжин ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон зэрэг дэвийг бууруулахгүй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 6 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 127

Улаанбаатар
хот

**Шүүхийн ерөнхий шүүгчийг
томилох тухай**

Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Бандийн Одонцэцэгийг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 6 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар
хот

**Шүүгчдийг албан тушаалаас
огцруулах тухай**

Шүүхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг үндэслэн Нямжавын Баярааг Говь-Сүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээс, Бямбын Давасүрэнг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээс тус тус огцруулсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 131

Улаанбаатар
хот

**Шарамн Гунгаадоржийг элчин сайдын
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Өөр ажилд томилогдсонтой нь холбогдуулан Шарамн Гунгаадоржийг Монгол Улсаас БНАСАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 132

Улаанбаатар
хот

**Д. Бямбааг элчин сайдаар
томилдох тухай**

Монгол Улсаас БНАСАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Дамдины Бямбааг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 133

Улаанбаатар
хот

**Дамбийнямын Жанчивыг Монгол Улсын
Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор
шагнах тухай**

Тайз, дэлгэцийн болон дан хөгжмийн олон арван бүтээл, ном зохиол туурвиж, урлагийн наадам, тэмцээн, үзлэг зэрэг улсын хэмжээний урлаг, уран сайхны томоохон арга хэмжээнүүдийг чадамгай зохион байгуулж, хөгжмийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монголын урлагийн ажилтны нийгэмлэгийн холбооны хорооны нарийн бичгийн дарга Дамбийнямын Жанчивыг Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор шагнасугай.

Монгол Улсын ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 6 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар
хот

**Бандийн Гэлэгийг Монгол Улсын
Спортын гавьяат дасгалжуулагч
цолоор шагнах тухай**

Биеийн тамир, спортын байгууллагад дасгалжуулагчаар олон жил үр бүтээлтэй ажиллаж бөхийн чөлөөт, самбо, жу-до барилдааны төрлөөр тив, дэлхийн болон улсын хэмжээний зэрэг цолтой олон арван тамирчид, дасгалжуулагчдыг сургаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Бандийн Гэлэгийг Монгол Улсын Спортын гавьяат дасгалжуулагч цолоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

**Шүүгчийг албан тушаалаас чөлөөлж
томилох тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Нацагдоржийн Баяраг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, мөн аргагүйн шүүхийн шүүгчээр томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

**Рэнцэнгийн Цэрэндуламд Монгол Улсын
шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн
цол олгох тухай**

Шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол орны бэлчээр, хадлангийн өвс ургамлын найрлага, шимт чанарыг судлан малын тэжээл, тэжээллэгийн тохистой хэмжээг тогтоож, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар дорвитой олон бүтээл туурвиж эрдмийн болон мэргэжлийн боловсон хүчин сургаж бэлтгэх, хөдөө аж ахуйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөдөө аж ахуйн үндэсний их сургуулийн Мал аж ахуйн хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан Рэнцэнгийн Цэрэндуламд Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар
хот

**Балдандоржийн Батхүүд Монгол
Улсын гавьяат уурхайчин цол
олгох тухай**

Экскаваторын машинч, ширэм хайлуулах цехийн даргаар олон жил үр бүтээлтэй ажиллаж хөрс хуулалт, нүүрс гаргалтын төлөвлөгөөт даалгаврыг тогтмол давуулан биелүүлж, ширэм хайлуулах цех байгуулан аж ахуйн тооцоон дээр ажиллуулан үйлдвэрийн технологийн үйл ажиллагаанд чухал шаардлагатай 10 гаруй нэр төрлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэж төвийн районуыг нүүрсээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Шарын гол" хувьцаат компанийн ширэм хайлах бригадын дарга Балдандоржийн Батхүүд Монгол Улсын гавьяат уурхайчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

**Төрийн тусгай хамгаалалтын алба
хаагчийн тангараг өргөх журмыг
батлах тухай**

1. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн "Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ зарлигийг 1995 оны 7 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
1995 оны 151 дүгээр зарлигийн
хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН АЛБА ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

1. Монгол Улсын иргэн төрийн тусгай хамгаалалтын албанд анх орохдоо Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг /цаашид энэ журамд "тангараг" гэх/-ийг ёс төртэй өргөнө.

2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч өөр байгууллагад шилжин ажилласны дараа Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаар эргэж томилогдвол тангараг дахин өргөхгүй.

3. Тангараг өргөх ёслолыг Төрийн тусгай хамгаалалтын газар зохион байгуулна.

4. Тангаргийг хамт олноор болон ганцаар өргөж болно.

5. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд Тагнуулын төв газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын албанд анх орж байгаа ажилтныг шууд захирах албан тушаалтан оролцоно.

6. Тангараг өргөх ёслолын байр /газар/, хугацааг Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга тогтоож, Төрийн тусгай хамгаалалтын газрын бөлөвсөн хүчний асуудал эрхэлсэн ажилтан, эсхүл төрийн тусгай хамгаалалтын газрын даргын томилсон албан тушаалтан бэлтгэл ажлыг зохион байгуулж тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдана. Тангараг өргөх ёслолын байр /газар/-нд Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

7. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаар томилогдсон иргэн тангараг өргөх ёслолын байр /газар/-нд тогтоосон цагт байраа эзлэн Монгол Улсын төрийн сүлд рүү харж цэх зөгсоно. Хамт олноор тангараг өргөх ёслолд жагсаж зөгсоно.

8. Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж буй ажилтан тангараг өргөх алба хаагчийг танилцуулан, тангаргийн бичгийг тангараг өргөгч бүрт гардуулна.

9. Тангаргийг хамт олноор өргөхөд тухайн нэгжийн дарга Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангаргийг цээжээр дээдлэн дуудаж бусад нь дагалдана. Тангаргийг ганцаар өргөх үед тангараг өргөгч тангаргийг цээжээр дээдлэн дуудна.

10. Тангаргийг цээжээр дээдлэн дуудаж дуусаад тангараг өргөгч төрийн сүлдэнд ёсолж мэхийн хүндэтгээд дараа нь төрийн далбааны өмнө очиж зүүн өвдөг сөхрөн адис авна.

11. Тангараг өргөсөн Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангаргийн бичигт тангараг өргөсөн он, сар, өдөр, газар, овог, нэрээ бичиж гарын үсэг зурна.

12. Тангараг өргөж дуусмагц хөгжимд Төрийн дуулал эгшиглэнэ.

13. Төрийн дуулал эгшиглэж дуусмагц тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөсөн алба хаагчид баяр хүргэж тангараг өргөх ёслолын ажиллагааг хаана.

14. Тангаргийн бичгийг тухайн алба хаагчийн хувийн хэрэгт хадгална.

15. Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тодорхой тэмдэглэл хөтлөнө.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

**Зарлиг хүчингүй болсонд
тооцох тухай**

1. "Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөлийг татан буулгах тухай" Монгол Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны 59 дүгээр тогтоолыг үндэслэн "Түр зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах ажилд идэвх зүтгэл гарган ажилласан тус зөвлөлийн гишүүдэд талархал илэрхийлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 9 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн дарга Г. Сонд даргалж гдшүүдэд Д. Чилхаажав, С. Жанцан, Ч. Энхбаатар, Л. Баасан, /илтгэгч/, хуралдааны нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуулж хийв.

Хуралдаанд гомдол гаргагч иргэн Д. Ламжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Төмөр нар оролцов.

1. Дондовын Ламжав Цэцэд хандаж 1995 оны 5 дугаар сарын 22-нд гаргасан өргөдөлдөө: Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт, Монгол Улсын Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтууд Монгол Улсын үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т байгаа онц болон дайны бэйдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэсэн заалтыг зөрчиж байгааг хянан үзэхийг хүсье гэжээ.

2. Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Ч. Энхбаатар 1995 оны 6 дугаар сарын 9-нд 6 тоот тогтоол гарган энэхүү маргааныг 1995 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт гаргасан гэдэг үндэслэлээр иргэн Д. Ламжавын гомдлын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт холбогдох хэсгийг хүлээн авахаас татгалзаж бусад асуудлаар маргаан үүсгэжээ.

3. Цэцийн гишүүн Г. Нямдоо, С. Жанцан, Д. Чилхаажав нарми бүрэлдэхүүнтэй 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар холбогдох асуудлын талаар иргэн Д. Ламжаваас дахин гаргасан гомдлыг хянан хэлэлцээд:

1. Өргөдлийн зарим хэсгийг хүлээн авахаас татгалзсан Цэцийн гишүүн Ч. Энхбаатарын тогтоолыг хүчингүй болгох.

2. Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Үндсэн хуулийг зөрчиж байгаа эсэх тухай маргааныг үүсгэсэн 02 тоот магадлалыг гаргажээ.

3. Иргэн Д. Ламжавын гомдлын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц 1995 оны 3 дугаар сарын 9-нд Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2, 6 дугаар зүйлийн 3, 16 дугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2, 6 дугаар зүйлийн 3, 16 дугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн 03 тоот дүгнэлт, 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн 04 тоот дүгнэлтүүдийг тус тус гаргасан байна.

4. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Төмөр Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбартаа: юуны өмнө Цэцийн хуралдаанд урьд нь оролцож чадалгүй хуралдаан хойшлуулах шалтгаан болгосондоо хүлцэл өчье. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц газрын тухай хуультай холбоотойгоор 3 удаа хуралджээ. Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэх үед манай хоёр гишүүний гаргасан тайлбар бол Улсын Их Хурлын тайлбар биш, тэдгээрийн өөрсдийн нь санал бодол болно.

Иргэн Д. Ламжав газар өмчлүүлэх асуудлаарх түүхэн асуудлыг хөнджээ. Монголд газар өмчлөх асуудал өнөө үед байсан зүйл биш Хүнийгний үеийн асуудал юм шүү. Энэ талаар судлаачид бичжээ.

Иргэнд газар өмчлүүлэх асуудал Монгол Улсын үндсэн хуульд тодорхой асуудал болно. Цэцийн хуралдаанд хэлэлцэж буй гомдолтой холбоотойгоор зарим тайлбар хийе.

1. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд онц ба дайны байдал зарласан үед хүний зарим эрхийг хуулиар хязгаарлах тал бий. Энэ заалт бод иргэн Д. Ламжавын үзэж байгаа шиг иргэнд газар өмчлүүлэх, өмчийн харилцаатай холбоотой асуудал биш ээ. Нөгөө талаар Улсын Их Хурал бол хуулиа тайлбартайгаар хийх эрхтэй бөгөөд энэ талаар Олон улсын эдийн засаг, нийгэм, соёлын

пактаар зөвшөөрсөн асуудал. Энэ чиглэлээр Монгол Улсын иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт гарчээ.

2. Улсын Их Хуралд газар зохион байгуулалтын ба кадвастрын гэх мэт иргэнд газар өмчлөхтэй холбоотой хуулийг Засгийн газраас оруудж ирсэн боловч Улсын Их Хурал төслийг буцаасан. Энэ нь газартай холбоотой урьдчилан шийдвэрлэгдэх газрын үнэлгээ, бусад тооцоо гэх мэт асуудалтай холбоотой. Газрын үнэлгээ гаргах, судалгаа явуулах зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагаанд Монгол Улсын одоогийн нэг жилийн төсөв зарцуулагдах гэх мэт асуудал бий. Ийм нөхцөлөөс болоод иргэнд газар өмчлүүлэх асуудлыг Улсын Их Хурал авч хэлэлцээгүй хойшлуулсан. Энэхүү агуулгаар Монгол Улсын иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт гарсан ба энэ бол Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийг зөрчсөн гэж үзэхгүй байна.

3. Өнөөдрийн хуралдаанд тавигдаж буй улс төрийн чанартай асуултуудад хариу өгөхгүй гэж бодож байна. Энэ бол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх хэмжээний асуудал биш болно гэв. Гомдол гаргагч иргэн Д. Ламжав Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт нь Үндсэн хуульд заасан иргэний эрхийг хязгаарласан, дордуулсан байна. Энэхүү хязгаарлалтыг онц болон дайны байдал зарласан үед хийж болох асуудлыг, ердийн нөхцөлд хийсэн учраас Иргэний хуулийн энэхүү заалт Монгол Улсын үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дэх заалтыг зөрчиж байна. Энэ томъёоллоо дараахь байдлаар танилцуулъя:

1. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд иргэний эрх хуулиар хязгаарлагдах ёстой. Гэтэл ийм байдал гараагүй үед Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт нь иргэний эрх, чөлөөг дордуулж, Монгол Улсын үндсэн хуулийг зөрчиж байна.

2. Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 7 дугаар зүйлийн 3-т Монгол Улсын үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий ВНМАУ-н хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг энэхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хориглоно. Монгол Улсын Үндсэн хуульд харшлагагүй Монгол Улсын хууль ба олон улсын гэрээний хүний эрхийн талаарх заалт зөрчилдвөл уул гэрээний заалтыг баримтална гэж заасан. Учир нь хүний эрхийг дордуулсан Монгол Улсын хуулийн заалтыг 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөх болсон. Гэтэл

хүний эрхийг дордуулсан БНМАУ-ын хуулиуд, тэдгээрийн заалтыг 1992 оны 2 дугаар сарын 12-ноос хэрэглэхийг хоригложээ.

3. Улсын Бага Хурлаас 1990 оны 12 дугаар сарын 6-нд баталсан "БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-иар бол Монгол Улсын иргэн 1990 оноос 1995 оны 1 дүгээр сарын 1 хүртэл газар өмчлөх эрхтэй байсан боловч 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс энэхүү эрх хасагдах болов.

4. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлийн 1-т хүн бүр эд хөрөнгийг хувьдаа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй 2-т хэний ч эд хөрөнгийг дураар хураан авч болохгүй гэсэн олон улсын хэм хэмжээтэй Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт нийцэхгүй байгаа юм. Эдгээр нь Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын үндсэн хуультай зөрчилдөж байгааг тодорхой зох нөхцөл болно.

Эцэст нь хүсэлт болгоход Монгол Улсад иргэн газар өмчлөх эрхтэй эсэхийг Үндсэн хуулийн Цэц дүгнэлтэндээ хэлж өгөхийг хүсье гэжээ.

Хянавал:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3-т зааснаар Монгол Улсын иргэдийн . . . газар өмчлөх эрх эдлэх нь нээлттэй байгаа бөгөөд энэхүү эрхийг хэрэгжүүлэх журмыг хуулиар баталж мөрдөөгүй байна. Ийм нөхцөлд газар өмчлөлтэй холбоотой харилцаанд төр газрын өмчлөгчийн үүргийг хэрэгжүүлж байхаар Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4-т хуульчилсныг Монгол Улсын Иргэний газар өмчлөх эрхийг хязгаарласан гэх үндэслэлгүй байна.

2. Монгол Улсад иргэн газар өмчлөх эрхтэй болох тухай Монгол Улсын үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 03 тоот дүгнэлтийн хяналтын хэсэгт санал нэгтэй тэмдэглэсэн байна.

3. Иргэн Д. Ламжавын гаргасан гомдолтой холбогдох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж гаргасан дүгнэлтийн хяналтын хэсэгт Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж тэмдэглэсэн байна.

Иймд иргэн Д. Ламжавын хүсэлтийг хангах үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчөөгүй гэж үзсүгэй.

2. Монгол Улсын Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 4дэх заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн тухай маргааныг Үндсэн хуулийн Цэц 1995 оны 7 дугаар сарын 4-нд шийдвэрлэн 04 тоот дүгнэлт гаргасан болохыг дурдсугай.

3. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж хариуг манайд ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилж байна.

ДАРГА

ГИШҮҮД

Г. СОВД

Л. БААСАН
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ
Ч. ЭНХБААТАР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

**Ахмад дайчдад буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад 6000 төгрөгийн нэг удавгийн буцалтгүй тусламжийг орон нутгийн төсвөөс энэ оны 9 дүгээр сарын 1-ний дотор багтван олгохыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт даалгасугай.

2. Энэ тогтоолыг 1 дүгээр зүйлд Халх голын 1939 оны байлдаан болон тус улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад дайчдыг нэг адил хамруулж, тэдэнд завсан хэмжээний буцалтгүй тусламжийг олгохоор тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Ч. ПҮРЭВДОРЖ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

**Хэрэглэгчдэд түгээх эрчим хүч,
усыг тоолуураар хэмжиж тооцох
тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хэрэглэгчийн онцлогийг харгалзан зохих бэлтгэлийг нь хангуулсны үндсэн дээр тэдний хэрэглэсэн цахилгаан, дулааны

эрчим хүч болон усны тооцоог дараахь хугацаанаас эхлэн тоолуураар хийж байх нь зүйтэй гэж үзсүгэй:

а/ төвийн эрчим хүчний системээс цахилгаанаар хангагддаг 200 кВт-аас дээш суурилуулсан чадал бүхий хэрэглэгчдэд түгээсэн цахилгаан эрчим хүчийг 1996 оны 4 дүгээр сарын 1-нээс, цахилгааны бусад хэрэглэгчдийнхийг 1998 оны 9 дүгээр сарын 1-нээс;

б/ шинээр барих, өргөтгөж шинэчлэх аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууцны барилга байгууламжид түгээх цахилгаан, дулааны эрчим хүч, усыг 1996 оны 6 дугаар сарын 1-нээс;

в/ одоо ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад түгээх дулааны эрчим хүч, усны тооцоог 1998 оны 1 дүгээр сарын 1-нээс.

2. Хэрэглэгчдийг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд дурдсан хугацаанд багтаан цахилгаан, дулааны эрчим хүч, усны тоолууртай, болгох арга хэмжээ авахын хамт одоо ашиглагдаж байгаа орон сууцанд дулааны эрчим хүч, ус дамжуулж байгаа системд ерөнхий тоолуур тавьж эрчим хүч, усаар хангагчдын болон орон сууцны байгууллагын хоорондын тооцоог тоолуураар хийх боломжийг 1998 онд багтаан бүрдүүлэх, цаашид айл бүрийг тоолуурт шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Эрчим хүч, геологи, уул уурхайн яам /Б. ЖИГЖИД/, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасгай.

3. Төлбөр тооцоо, хэмжил зүйн орчин үеийн шаардлага хангасан тоолуур, тэдгээрийн эд анги хийгээд тоолуурыг суурилуулах, баталгаажуулах зориулалттай багаж хэрэглэл, материал импортлогчийг Эрчим хүч, геологи, уул уурхайн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам, Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн тодорхойлолтыг үндэслэн гваллийн албан татвараас 50 хувь хөнгөлж, худалдааны албан татварыг 100 хувь чөлөөлж байсугай.

4. Бүх төрлийн барилга байгууламжийн дулааны алдагдлыг багасгах, дулааны эрчим хүч, усны хэрэглэгчдийг тоолууржуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагад нийцүүлэн барилгын хийцийн техник, эдийн засгийн онцвочтой шийдлийг сонгох, норм, стандартыг боловсронгуй болгож талаар холбогдох яам, газартай хамтран төсөл боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Дэд бүтцийн хөгжлийн яам /Р. САЙДАЛХАН/-д даалгасгай.

5. Эрчим хүч, усыг хэмнэх арга зам, ач холбогдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж байхыг Эрчим хүч, геологи, уул уурхайн яам /Б. ЖИГЖИД/, аймаг, нийслэлийн

Засаг даргын тамгын газар, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
/Б.ӨВГӨНХҮҮ/, "Засгийн газрын мэдээ" сонин газар /Х.Цэвлээ/-
т даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Эрчим хүч, геологи,
уул уурхайн сайд

Б. ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж,
идэвхжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, идэвхжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

2. Гадаад орнуудад төлөх зээлийн урсгал өрийг голчлон үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр төлж байхын хамт төсвийн хөрөнгөөр санхүүжигддэг цэрэг, иргэний хамгаалалтын болон бусад байгууллагын хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг аль болохоор дотоодын үйлдвэрлэлээс хангахаар тооцож, 1995 оноос эхлэн үйлдвэрлэгчдийн дунд тендер зарлан шалгаруулах замаар улсын захиалга өгч ажиллахыг холбогдох яам, тусгай газар, нийслэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Худалдаа, үйлдвэрийн сайд

Ц. ЦОГТ

Сангийн сайд

Э. БЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 69
дүгээр тогтоолын хавсралт

**ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИЖ,
ИДЭВХЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
А	1	2	3

1. Үйлдвэрлэлийн дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлд шаардагдах эрчим хүч, дулаан, харилцаа холбоогоор найдвартай хангах арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх, энэ салбар дахь төрийн монополийг ажмаар халж өрсөлдөөнийг буй болгоход гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах бодлого баримтлах

1995
оноос

Ч. Улаан,
Б. Жигжид,
Р. Сандалхан
2. Үйлдвэрлэлийн бүтэц, байршлыг оновчтой болгох талаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх:
 - а/ орон нутгаас татах, хүргэж түгээх материал, түүхий эдийн тээврийн зардлыг хямдруулах үүднээс орон нутагт чанарын өндөр түвшинд анхан шатны боловсруулалт хийх жижиг, дунд үйлдвэрүүдийг түүхий эдийн нөөцөд тулгуурлан оновчтой байршлаар бий болгох, уул уурхай, хүнс, өргөн хэрэглээний бараа, барилгын материалын жижиг үйлдвэрүүдийг дэд бүтцэд тулгуурлан хувийн хэвшлийн

1995

Ц. Цогт,
Ч. Улаан,
Б. Жигжид,

А	1	2	3
бүх хэлбэрээр хөгжүүлэхийг дэмжих;		IV улирлаас	Ц. Өөлд, Р. Сандалхан,
б/ гутал, оёдол зэрэг салбарт үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүчин чадлыг бүрэн ашиглах, орон нутагтажлын байр шинээр бий болгох зорилгоор үйлдвэрлэлийн шугамуудыг хөдөө орон нутагт шилжүүлэн байрлуулж орон нутгийн хэрэгцээг хангах ба чөлөөлөгдсөн суд талбайд шинээр өөр төрлийн үйлдвэрлэл зохион байгуулахад бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлэх;		- " -	Ц. Цогт, Ч. Улаан,
в/ одоогийн томоохон үйлдвэрүүдийг олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чиглүүлэх тэдгээрийн техник, технологийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх, үүнд зориулан гадаад орны банкнаас арилжааны зээл авахад баталгаа гаргах журам боловсруулж Засгийн газарт оруулах		1995 оны Х сарын 1-ний дотор	Э. Бямбажав Ц. Цогт, Ч. Улаан,
3. "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай" Монгол Улсын хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд оруулах		1995 оны IX сарын 1-ний дотор	Ц. Цогт, Ч. Улаан, Н. Лувсанжав
4. Жижиг үйлдвэрүүдэд төлөвлөгөө, стратеги боловсруулах, санхүүжүүлэх бүтээгдэхүүнээ борлуулах, үйлдвэрлэлт, экспортоо нэ-			

А	1	2	3
	<p>мэгдүүлэх, зах зээлээ сонгох зэрэг аж ахуйгаа эрхлэн явуулах талаар зөвлөлгөө өгөх, дэмжин туслах мэргэжлийн байгууллага ажиллуулах, түүнийг түшиглэн байнгын сургалт зохион явуулж байх, үүнд хандивлагч орнуудын техникийн туслалцааг ашиглах журам тогтоон хэрэгжүүлэх</p>	<p>1995 оноос</p>	<p>Ч. Улаан, Ц. Цогт,</p>
5.	<p>Зах зээлийн эдийн засгийн шилжилтэд төрийн бодлогын болон хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг оновчтой зөв тогтоох, тэдгээрээс аж ахуйн байгууллагатай харилцах асуудлыг шилжилтийн үе шаттай уялдуулан тодорхойлж мөрдүүлэх</p>	<p>1995 оноос</p>	<p>Л. Энэбиш</p>
6.	<p>Гадаад орнуудаас ивах зээлийг Монгол Улсын төлбөрийн чадахийг дээшлүүлэх зорилгоор экспортын зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрт олгох чиглэл баримталж ажиллан, хандивлагч орнуудын Засгийн газрууд, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагатай хэлэлцээ хийх</p>	<p>1995 оноос</p>	<p>Ч. Улаан, Ц. Цогт, Э. Бямбажав</p>
7.	<p>Хөрш зэргэлдээ орнуудад нийлүүлэх Монголын экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх нөхцөл бололцоо бүрдүүлэх чиглэлээр</p>		

А	1	2	3
тэдгээр орим Засгийн газрын холбогдох байгууллагатай хэлэлцээ явуулж дунг Засгийн газарт танилцуулах	1995 ойм II-III улирал	Ц. Цогт, Ц. Гомбосүрэн, Ч. Улаан	
8. Монголын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, хармагийг жил бүр зохион байгуулах, шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг шалгаруулах, шалгарсан үйлдвэрлэгчдийг тухайн жилд олгох зээл, тусламжид эхний ээлжинд хамруулан, олон улсын үзэсгэлэн хармагт оруулж байх арга хэмжээг Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран авах	1995 оноос	Ц. Цогт, Ч. Улаан,	
9. Дэлхийн болон олон улсын стандартад тэнцэх сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн үйлдвэр, аж ахуйн газар, шилдэг бизнесменийг шалгаруулах тусгай шагнал олгох журам боловсруулах	1995 ойм III улирал	Ц. Цогт, Ц. Өөлд, Б. Жигжид, Э. Бямбажав, Р. Саидалхан	
10. "Гаалийн тарифын тухай" Монгол Улсын хуулийн төслийг боловсруулах	1995 ойм III улирал	Ц. Цогт, Б. Шаравсамбуу, Н. Лувсанжав	
11. Төсвийн хөрөнгөөр санхүүжигддэг арга хэмжээнд зориулан Засгийн газраас үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүний захиалга өгөх, бүтээгдэхүүн худалдан авах журмыг боловсруулж мөрдүүлэх	1995 ойм III улирал	Ц. Цогт, Э. Бямбажав, Ч. Улаан,	

А	1	2	3
12.	Аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхойлох	1995 онд	Ц. Цогт, Ч. Улаан Р. Сандалхан З. Батжаргал
13.	Бөөний худалдааны сүлжээ байгуулах, хөдөө орон нутагт худалдаа, үйлчилгээ хөгжүүлэх түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид болон үйлдвэрлэгчид хоршин ажиллах идэвх санаачилгыг бүхий л талаар дэмжин, эрх зүйн үндсийг нь бүрдүүлэх талаар санал боловсруулах	1995 онд	Ц. Цогт, Ц. Өөлд, Э. Бямбажав
14.	Тоног төхөөрөмж нь хувьчлагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай зарим барилгыг хуулийн дагуу хувьчлах	1995-1996 онд	Л. Энэбаш, Э. Бямбажав,

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

**Худалдааны албан татвар ногдуулах,
төлөх, тайлагнах журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Худалдааны албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг; Монгол Улсын Их Хурлын 1994 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны үндсэн чиглэл"-ийн Макро эдийн засгийн бодлогын талаархи I хэсгийн 4 дүгээр зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

"Худалдааны албан татварын тухай" Засгийн газрын 1992 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 87 дугаар тогтоолоор баталсан "Худалдааны албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам"-д дараахь өөрчлөлт оруулж 1995 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж мөрдүүлсүгэй:

а/ 3 дугаар зүйлийн "б" заалтад "-бөөний худалдаа, хангамжийн байгууллага" гэсэн нэмэлт оруулах;

б/ 13, 16 дугаар зүйлүүдэд "... үнэлгээний 10 хувиар ..." гэснийг "... үнэлгээний тогтоосон хувиар ..." гэж өөрчлөх;

в/ 17 дугаар зүйлийн "... импортолж авсан бараанд ..." гэснийг "... импортолж авсан бараа, материал, сэлбэгт ..." гэж өөрчлөх;

г/ 19 дүгээр зүйлийн "г" заалтыг хасах.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Худалдаа, үйлдвэрийн сайд

Ц. ЦОГТ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

**Соёл, урлаг хөгжүүлэх
сангийн тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Соёл, урлаг хөгжүүлэх сан бий болгож, дүрмийг нь хавсралтын
бсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Соёлын сайд

Н. ЭНХВАЯР

Сангийн сайд

Э. БЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 74
дүгээр тогтоолын хавсралт

СОЁЛ, УРЛАГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Соёл, урлагийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилго бүхий "Соёл, урлаг хөгжүүлэх сан" (цаашид "Сан" гэнэ) байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах, арвижуулах үйл ажиллагаанд энэ дүрмийг дагаж мөрднө.

2. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, ашиглалт, зарцуулалтыг Соёлын нам хариуцна.

3. Сангийн хөрөнгийг арвижуулах, зориулалтын дагуу үрдүштэй ашиглах, захиран зарцуулах асуудлыг хариуцаж өдөр тутмын үйл ажиллагааг нь удирдах, холбогдох санал боловсруулж, Соёлын сайдын зөвлөлөөр оруулан шийдвэрлүүлэх үүрэг бүхий сангийн захирал (орон тооны бус)-ыг Соёлын сайдын тушаалаар томилно. Сангийн өдөр тутмын ажлыг намны ажил төрлийн хэлтэс хариуцаж, бүртгэл тооцоог захиргааны нягтлан бодогч хөтөлнө.

4. Сангийн үйл ажиллагааг зүй зохистой явуулахад ерөнхий хяналт тавих, хөтөлбөр, төсөлд үнэлэлт дүгнэлт өгөх; шинэ уран бүтээл, соёл, урлагийн тодорхой төсөл сонгон шалгаруулах үүрэг бүхий сангийн орон тооны бус зөвлөл байгуулан ажиллуулж болно. Сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг Соёлын сайдын тушаалаар батална.

5. Сангийн захирал Соёлын яамны тэмдэг, албан бичгийн хуудас хэрэглэнэ. Сан нь банкинд данстай байна.

ХОЁР. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах

6. Сангийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

а/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс шинэ уран бүтээл хийх, улсын болон бүс нутгийн чанартай соёл, урлагийн томоохон арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэхэд зориулан өгсөн хандив, тусламж;

б/ соёл, урлагийг хөгжүүлэхэд зориулан гадаад орон, олон улсын байгууллага, гадаадны иргэдээс өгсөн хандив, буцалтгүй тусламж;

в/ сангийн хөрөнгөөр зохион байгуулсан урлагийн тоглолт, уран бүтээлийн үзэсгэлэнгийн орлого;

г/ сангийн хөрөнгийг зүй зохистой байршуулж эргэлтэд оруулсан болон сангийн хөрөнгөөр бий болсон эд зүйлсийг борлуулснаас олох орлого;

д/ төсвийн хөрөнгө;

е/ банкны зээл (тодорхой төсөл санхүүжүүлэх);

ж/ бусад эх үүсвэр.

7. сангийн хөрөнгийг Сангийн зөвлөлөөс гаргасан үнэлэлт дүгнэлт болон сонгон шалгаруулахын дүнг харгалзан дараахь арга хэмжээг санхүүжүүлэх, зээлжүүлэхэд зориулан зарцуулна:

а/ шинэ уран бүтээл туурвих;

б/ чухал ач холбогдолтой ном, соёл, урлагийн зориулалттай мэргэжлийн сонин, сэтгүүд, цомог хэвлүүлэх, дүрс бичлэгийн болон дуу авианы бичлэг хийлгэх;

в/ Соёлын сайдын зөвлөлийн шийдвэрийн дагуу үндэсний соёл, урлагийн тоглолтыг гадаад орнуудад зохион байгуулахад зээл олгох;

г/ улсын хийгээд бүс нутгийн чанартай урлаг, уран сайхан, соёлын томоохон арга хэмжээ зохион байгуулах;

д/ урлагийн шинэ төрөл, чиглэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

е/ соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал олж бэлтгэх.

8. Сангийн хөрөнгө нь Засгийн газрын тусгай зориулалтын санд хамаарагдах бөгөөд улсын төвлөрсөн төсвийн бүрэлдэхүүнд орно.

ГУРАВ. Сонгон шалгаруулсан төслийг санхүүжүүлэх

9. Шинэ уран бүтээл, ном зохиол, соёл урлагийн тодорхой төслийг өрсөлдүүлж сонгон шалгаруулна. Шинэ уран бүтээл, ном зохиол, төсөл өрсөлдүүлж сонгон шалгаруулах, шалгарсан бүтээлийг санхүүжүүлэх, зээл олгох журмыг Соёлын сайд Сангийн сайдтай тохиролцон баталж мөрдүүлнэ.

10. Сонгон шалгаруулсан уран бүтээл, ном зохиол, төслийг захиалагч, гүйцэтгэгч болон сангийн захирлын хооронд байгуулсан гэрээг үндэслэж санхүүжүүлнэ. Тэгэхдээ гэрээний заалт нь энэхүү дүрмийн заалттай нийцсэн эсэхийг Соёлын яам хянана.

11. Гэрээнд захиалагчаас тавьсан шаардлага, гүйцэтгэгчийн хүлээх хариуцлага, сангавс санхүүжүүлэх зарчим, үе шат, хугацаа, зээлийг эргэж төлөх хугацаа, зээлийн хүү, түүнчлэн үр дүнг тооцох журам зэргийг тусгасан байна.

12. Сангийн захирал нь захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээ тогтоосон хугацаанд хамтран дүгнэж, санхүүжилтийн үр дүнгийн тооцоо хийж байдмын хамт төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа зохих хэмжээгээр хэрэгжиж биелсэн нөхцөлд санхүүжилтийг хийх бөгөөд зээлийг хугацаанд нь төлүүлэх үүргийг Соёлын сайдын өмнө биечлэн хариуцна.

ДӨРӨВ. Сангийн захирлын үүрэг, эрх

13. Сангийн захирал нь дор дурдсан үндсэн үүрэг хүлээнэ:

а/ сангийн хөрөнгийг бүрдүүдэх ажил эрхлэх, уг хөрөнгийг ариунжуулж энэ дүрэмд заасны дагуу үр өгөөжтэй ашиглан зарцуулах;

б/ соёл, урлагийн сангийн үйл ажиллагааны талаар сурталчлах, сангийн хөрөнгийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулах;

в/ сангийн хөрөнгийн зарцуулалтын явц, санхүүжүүлсэн шинэ уран бүтээл, төслийн үр дүнг Соёлын сайдын зөвлөлд улирал тутам тайлагнаж байх;

г/ сангийн хөрөнгийг бусдад хандивлах, дэнчин тавих, зорлуудат бусвар болон зохих гэрээгүйгээр зарцуулах аливаа үйл ажиллагааг хэвч байх;

д/ сангийн хөрөнгийн орлого, зарлагын тайланг зохих хууль тогтоомж, журмын дагуу Соёлын нам, Сангийн яаманд хугацаанд нь гаргаж өгөх.

14. Сангийн захирал нь дор дурдсан эрхтэй байна:

а/ сангийн хөрөнгийг өсгөн арвижуулахын тулд хууль тогтоомжийн хүрээнд дотоод, гадаадад үйл ажиллагаа явуулах, худалдааны болон хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулах;

б/ санхүүжүүлж, зээлжүүлж байгаа уран бүтээл, төсөл, арга хэмжээний явцыг холбогдох аж ахуйн нэгж байгууллагад шалгах, үр дүнг тооцож гаргуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох өр төлбөр барагдуулах арга хэмжээ явах, холбогдох санал боловсруулж Соёлын нам, бусад байгууллагад тавих;

в/ санхүүжүүлсэн уран бүтээл, ном хэвлэл, төслийг хүлээн авч, гэрээгээр хүлээсэн үүргийг дүгнэх цаашид уг уран бүтээлийг ард түмний хүртээл болгох ажлын явцад хяналт тавих;

г/ сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, үрэгдүүлж шамшигдуулсан, түүнчлэн сангаас олгосон зээл, зээлийн хүүг төлөхөөс зайлсхийсэн аж ахуйн нэгж, байгууллага, хариуцсан ажилтанд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, нэхэмжлэл гаргах.

ТАВ. Бусад асуудал

15. Сангийн хөрөнгийн зарцуулагддаггүй үлдэгдлийг дараа онд шилжүүлэн зарцуулна.

16. Сангийн хөрөнгийг энэ дүрэмд тааснаас өөр арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

17. Сангийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, зээлийн төлбөрийн явцад Сангийн нам хяналт тавина.

18. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын жилийн тайлан, түүний үр дүнг харгалзан санд төсвөөс олгох хөрөнгийг Соёлын нам, Сангийн нам тухай бүр хамтран тооцож төсөвт тусгана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох журам"-ын хавсралт "Аж ахуйн нэгжээс зөвшөөрөлтэйгээр эрхлэн гүйцэтгэж болох үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалт"-д дараахь нэмэлт өөрчлөлт оруулсугай:

а/ жагсаалтын 14 дэх хэсгийг "14. Харилцаа холбооны бүх төрлийн ажил, үйлчилгээ - Дэд бүтцийн хөгжлийн яам" гэж өөрчилсүгэй;

б/ дор дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээг холбогдох яамны зөвшөөрөлтэйгээр явуулж байхаар жагсаалтад нэмж оруулсугай:

18. Барилгын зураг төсөл, хайгуулын ажил - Дэд бүтцийн хөгжлийн яам;

19. Радио, телевизийн нэвтрүүлэг явуулах - Радио, телевизийн хэрэг эрхлэх газар;

20. Авто тээврээр ачаа, зорчигчид тээвэрлэх, тээвэр экспедицийн болон зуучлах үйлчилгээ - Дэд бүтцийн хөгжлийн яам;

21. Агаарын хөлөг эзэмшин ачаа, зорчигч тээвэрлэх, түүнтэй холбогдсон ажил, үйлчилгээ - Дэд бүтцийн хөгжлийн яам, түүний эрх олгосноор Иргэний агаарын тээврийн байгууллага;

22. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл - Дэд бүтцийн хөгжлийн яам;

23. Гадаадад хөдөлмөр эрхлүүлэх талаар иргэдэд зуучаах үйлчилгээ явуулах - Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам;

24. Хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаа явуулах - Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам;

25. Арлжавын давтгалын үйл ажиллагаа эрхлэх - Сангийн яам".

Монгол Улсын Ерөнхий сайд	П. ЖАСРАЙ
Дэд бүтцийн хөгжлийн сайд	Р. САНДАЛХАН
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд	Э. ГОМБОЖАВ
Сангийн сайд	Э. БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог газар, нутгийн захиргааны байгууллага хийгээд улсын үйлдвэрийн газар, байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг холбогдох яам, газрын саналыг авч нэгтгэн боловсруулж 6 дугаар сарын 15-ны дотор Засгийн газрын хуралдаанд оруулахыг Монгол Улсын Шадар сайд Л. Энэбиш, Хууль зүйн сайд Н. Лувсанжав нарт даалгасугай.

2. Холбогдох сайд, тусгай газрын дарга нарт даалгах нь:

а) захиргааны хяналтын байгууллага, албадын дүрмийг Төрийн хяналт шалгалтын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн зүйл, заалтад нийцүүлэн 1995 оны 6 дугаар сард багтаан шинэчлэн боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулсугай;

б) захиргааны хяналтын төв байгууллагын дарга нарыг энэ оны 6 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт оруулан томилуулах арга хэмжээ авсугай.

3. Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын дарга (улсын ахлах байцаагч)-ыг захиргааны хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцсөний үндсэн дээр энэ оны 6 дугаар сард багтаан томилохыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Мэргэжлийн хяналтын байгууллага, албадын лабораторийн зориулалт, үндсэн үүрэг, тоног төхөөрөмж, хэмжих, хянах багаж хэрэгслийн хангалтын судалгааг нэгтгэн гаргаж, цаашид тэдгээрийг үр өгөөжтэй ашиглах талаар холбогдох хам, газартай хамтран энэ оны 3 дугаар улиралд багтаан тодорхой санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН)-т даалгасугай.

5. Төрийн хяналт шалгалтын талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүйн хам (Н. ЛУВСАНЖАВ)-д даалгасугай.

6. Аймаг, нийслэлийн хянан шалгах хороодыг эмхлэн байгуулах, тэдгээрийг ажиллах байр болон үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангах бэлтгэл ажлыг Засаг даргатай хамтран авч хэрэгжүүлэх, аймаг, нийслэлийн хянан шалгах хорооны дарга, гишүүдийг томилох ажлыг энэ оны 6 дугаар сард багтаан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвлөсүгэй.

7. Дор дурдсан асуудлыг энэ оны 6 дугаар сард багтаан боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах арга хэмжээ авахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (С. БАНЭРАГЧ)-т даалгасугай:

а) Засгийн газраас хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг мэдээлэх талаар мөрдөж байсан журамд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулах;

б) "Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих төрийн захиргааны хяналтын дүрэм"-ийг батлагдсан хуулиудад нийцүүлэн хянаж өөрчлөлт оруулах;

в) захиргааны хяналтыг хэрэгжүүлэх төв болон нутгийн захиргааны байгууллага, албадын бүтэц, зохион байгуулалт, харьяалал, ажлын зааг хуваарийг боловсронгуй болгох;

г) захиргааны хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдгийн загварыг гаргах.

8. Захиргааны хяналтыг хэрэгжүүлэх төв болон орон нутгийн байгууллагыг зохион байгуулж ажилд оруулсны дараа тэдгээрийн ажил төрлийн нэгдсэн семинарыг холбогдох бусад байгууллагатай хамтран 1995 онд багтаан зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Л. Энэбишид даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын шадар сайд

Л. ЭНЭВИШ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 81

Улаанбаатар
хот

Ашигт малтмалын жагсаалт батлах тухай

Монгол Улсын "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 35 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэдэд гэр ахуйн зориулалтаар түрээсийн төлбөргүйгээр эг удаа ашиглуулж болох ердийн ашигт малтмалын жагсаалтыг савсралтын ёсоор баталсугай.

2. Нэг удаагийн хэрэглээгээр авч ашиглаж болох ердийн ашигт малтмалын судалгаа, бүртгэл, тооцоо гаргаж, тэдгээрийн ашигтлалтад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Эрчим хүч, геологи, уул
уурхайн сайд

В. ЖИГЖИД

Засгийн газрын 1995 оны 81
дүгээр тогтоолын хавсралт

**ИРГЭДЭД ГЭР АХУЙН ЗОРИУЛАЛТААР ТҮРЭЭСИЙН
ТӨЛБӨРГҮЙГЭЭР НЭГ УДАА АШИГЛУУЛЖ БОЛОХ
ЕРДИЙН АШИГТ МАЛТМАЛЫН ЖАГСААЛТ**

- Элс
- Хайрга
- Кварцит
- Шавар
- Аргиллит (шаваржин)
- Алсвэролит (зануучин)
- Цэрд
- Шохойн чулуу
- Доломит (бадмар)
- Мергель (баргилт)
- Маагмын чулуулаг
- Галт уулын чулуулаг
- Хувирмал чулуулаг
- Занар

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 5 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар
10Т

**Зарим тогтоолыг хүчингүй болсонд
тооцох тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Үндсэн хуульд хууль тогтоомжийг нийцүүлэн шинэчлэх ажлын хүрээнд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, Засгийн газрын дор дурдсан тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай:

-“Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 250 дугаар тогтоол;

-“Нэр хаяггүй захидал, мэдээллийн тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1990 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 178 дугаар тогтоол;

-“Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх журмын тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 158 дугаар тогтоол.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Тогтоол, тогтоолын зүйл, заалт
хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын Иргэний хууль батлагдсантай холбогдуулан хавсралтад дурдсан Сайд нарын Зөвлөл, Засгийн газрын тогтоол, тогтоолын зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

Засгийн газрын 1995 оны 86 дугаар
тогтоолын хэвсрэлт

ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

Нэг. БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн

1. "Үйлдвэрүүдийн газруудаас өөрийн боловсруулан гаргасан үйлдэхүүнээсээ тусгай хуваарь ба баталгаа зөвшөөрөлгүйгээр үйлдвэрээсээ шууд гадагш худалдаалах явдлыг зогсоосон Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1932 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолын 6 дугаар зүйлд заасныг аж үйлдвэрийн комбинатаас биелүүлээгүй тухай" 1943 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 75 дугаар хурлын тогтоол.

2. "Импортын хар үнэгний жижиглэн худалдаалах үнийг хорогдуулах тухай" 1944 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 92 дугаар хурлын тогтоол.

Хоёр. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн

3. "Буу, зэвсэг олгох, ашиглах, хадгалах явдлыг журамтай болгох тухай" 1964 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 113 дугаар тогтоол.

4. "Барилгын материалын үйлдвэрийн замын санхүүгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1966 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 318 дугаар тогтоол.

5. "Улаанбаатар хотын албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагад орон сууцны байшин худалдах тухай" 1970 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 187 дугаар тогтоол.

6. 1972 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 339 дүгээр тогтоолоор баталсан "БНМАУ-ын газар эдэлбэрийн хуулийг биелүүлэх заавар"-ын 36 дугаар зүйл.

7. 1973 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан "Цахилгаан эрчим хүч ашиглах дүрэм"-ийн 47, 48 дугаар зүйл.

8. 1973 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 277 дугаар тогтоолоор баталсан "Орон сууцны хоршооллын үлгэрчилсэн дүрэм"-ийн 23 дугаар зүйл.

9. "Стандарт техникийн нөхцөлийг улс ардын аж ахуйд нэвтрүүлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1974 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 155 дугаар тогтоол.

10. "Гадаад улсын болон хувь нийлүүлсэн байгууллага, гадаад улсын иргэн, аль ч улсын иргэн биш хүмүүст газар эдлүүлэх журмын тухай" 1974 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 261 дүгээр тогтоол.

11. 1975 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 476 дугаар тогтоолоор баталсан "Дулааны эрчим хүч ашиглах дүрэм"-ийн 37, 38, 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 54, 57 дугаар зүйл.

12. "Ард иргэдийн дунд тэтгэврийн даатгал явуулах тухай" 1978 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр тогтоол.

13. "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 1983 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 161 дүгээр тогтоол.

14. "Газар эдлүүлэх тухай" 1984 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 30 дугаар тогтоол.

15. "Орон сууцны барилга шилжүүлэх тухай" 1986 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 211 дүгээр тогтоол.

16. "Монголын зохиолчдын эвлэлийн утга зохиолын фондын дүрмийг батлах тухай" 1986 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 325 дугаар тогтоол.

17. "Амины орон сууц барих талаар авах зарим арга хэмжээний тухай" 1987 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 254 дүгээр тогтоол.

18. "Хувьцаа гаргах журам тогтоох тухай" 1990 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоол.

19. "Амины орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай" 1990 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 403 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "а", "б", "в" заалт, 11 дүгээр зүйлийн "а" заалт.

Гурав. БНМАУ-ын Засгийн газрын

20. "Улаанбаатар хотын газрын үнэлгээ, газар ашигласны төлбөр тогтоох тухай" 1991 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 136 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "а" заалт, 4 дүгээр зүйлийн "... газрыг иргэдийн хувийн өмчид олгох..." гэсэн хэсэг.

21. "Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг өргөжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 1991 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 284 дүгээр тогтоолын 5 дугаар зүйл.

22. "Худалдааны байгууллагын зохион байгуулалтыг зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1991 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 317 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "а", "б" заалт.

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын

23. "Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний бэлтгэлийн үнийн тухай" 1992 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 34 дүгээр тогтоол.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 5 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Буудайн сангийн дүрэм батла тухай

Монгол Улсын "Хүнсний хууль", Улсын Их Хурлын 1994 оны 73 дугаар тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Буудайн сан"-гийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

2. "Буудайн сан"-г Хөтөл дэх улсын аюулаас хамгаалаг нөөцийн төвийг түшиглэн зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Өөлдөд даалгасугай.

3. Аюулаас хамгаалах улсын нөөцөд зориулан 1995 онд бүрдүүлбэл зохих буудайн хэмжээг 20,0 мянган тн-оор тогтоож, уг нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авахын хамт цаашид төсвөөс буудайн санд оруулах хөрөнгийг жил бүрийн төвлөрсөн төсөвт тусгаж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн яам /Ц. ӨӨЛД/, Сангийн яам /Э.БЯМБАЖАВ/-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Хүнс, хөдөө аж ахуйн сайд
Сангийн сайд

П.ЖАСРАЙ
Ц.ӨӨЛД
Э.БЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 88 дугаар
тогтоолоор батлав.

"БУУДАЙН САН"-ГИЙН ДҮРЭМ

"Буудайн сан" /цаашид "сан" гэнэ/-гийн дүрэм нь Монгол Улсын "Хүнсний тухай хууль"-д заасан стратегийн хүнсний зүйлд хамрагдах буудайг улсын нөөцөд худалдан авах, хадгалах, борлуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

Нэг. Сангийн үндсэн үүрэг

Сан нь улсын нөөцөд байх буудайг худалдан авах, шаардлагатай үед гурилын үйлдвэр, аж ахуйн нэгжид буудай нийлүүлэх, тэдний хэрэгцээнээс илүү гарсан буудайг зах зээлд борлуулахтай холбогдсон дор дурдсан үүрэг бүхий аж ахуйн нэгж мөн. Үүнд:

а/ажуулавс хамгаалах улсын нөөцөд хуримтлуулсан буудайг байгалийн тавламжгүй нөхцөлөөс болж ургац буурсан болон алдсан үед гурил үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн үндсэн түүхий эдийн хангамжийг тасалдуулахгүй байх;

б/гурил үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн хэрэгцээнээс илүү гарсан таваарын буудайг худалдан авч дотоод, гадаадын зах зээлд борлуулах.

Хоёр. Сан бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэр

Санг хөрөнгийн дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт;

б/гадаад улс, олон улсын байгууллагаас санд зориулан олгосон зээл, тусламжийн хөрөнгө;

в/сангийн үйл ажиллагаанаас олсон ашиг;

г/аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулсан хандив, тусламжийн хөрөнгө;

д/банкны зээл.

Гурав. Сангийн удирдлага

1.Сангийн удирдлага нь санд буудай худалдан авах, хадгалах, борлуулах үйл ажиллагааг Хүнс, хөдөө аж ахуйн яамны хяналт, зохицуулалтаар гүйцэтгэнэ.

2.Санд чанарын шаардлага хангасан буудайг биржээр дамжуулан үйлдвэрлэгчдийг ил тод өрсөлдүүлэн шалгаруулж зах

зээлийн үнээр худалдан авч хадгалах бөгөөд хуваарилах, борлуулах буудайн хэмжээг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын шийдвэрээр тогтооно.

Дөрөв. Сангийн үйл ажиллагаа

1. Сан нь буудай худалдан авах, түүнийг тээвэрлэх, цэвэрлэж хатаах, хадгалахдаа зохих технологийг чанд сахих аж ахуйн нэгжийн хуулийн дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

2. Сангийн хөрөнгө нь зөвхөн буудай худалдан авахад зориулагдах бөгөөд аж ахуйн нэгжээс тухайн жилд худалдан авахаар гэрээгээр тохирсон буудайн үнийн дүнгийн 30 хүртэл хувьтай тэнцэх урьдчилгааг холбогдох байгууллагын хөрөнгийн баталгаа болгож буудай нийлүүлэгчдэд гэрээгээр олгож болно. Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг зориулалт бусаар зарцуулах, бусдад эзэлдүүлэх, бэрцвэлэх, хандиа, тусламжид зарцуулахыг хориглоно.

3. Нөөцийн буудайг улсын нөөцийн агуулахаас гадна найдвартай агуулах бүхий гурилмын үйлдвэр, аж ахуйн нэгжид хадгалуулж болох бөгөөд энэ тохиолдолд хадгалалтын зардал, нөөцийн буудай худалдан авах хөрөнгийг сангаас гаргана.

4. Улсын нөөцөд авсан буудайг гурилмын үйлдвэр болох аж ахуйн нэгж, бусад байгууллагад тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан борлуулна.

5. Хадгалалтын хугацаа дуусах болсон буудайг зах зээлийн үнээр дотоод, гадаадын зах зээлд борлуулж, олсон орлогоороо нөхөн хангалт хийнэ.

6. Буудай нийлүүлэгч болох худалдан авагч аж ахуйн нэгж, сангийн хооронд гарсан маргааныг зохих журмын дагуу хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 3-н өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

Сорьцны улсын хяналтын дүрэмд
оөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 298 дугаар тогтоолоор баталсан "Сорьцны улсын хяналтын дүрэм"-ийн 4,9,12,13 дугаар зүйл болон 14 дүгээр зүйлийн "а", 16 дугаар зүйлийн "б" заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а/4. Сорьцны улсын хяналтыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд Сангийн яам Сорьцны улсын хяналтын албаар дамжуулан, орон нутгийн хяналтыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга Тамгын газрынхаа холбогдох хэлтэс, албаар дамжуулан тус тус хэрэгжүүлдэг.;

б/9. Үнэт металлын сорьцыг батлах дэрдсыг эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн Сорьцны улсын хяналтын албаны үнэт металлын чанар шалгах лабораториуд тавьж, үнэт металлын хэмжээг баталгаажуулна. Тухайн бүтээгдэхүүнийг хоёр буюу түүнээс дээш үнэт металаар хийсэн байвал аль их жинтэй хэсгийн сорьцны хэмжээг баримтлан баталгаажуулна.;

в/12. Үнэт металл, түүгээр хийсэн эдгээлийг шинжилж сорьц тогтоох, сорьцны тэмдэг дарж баталгаажуулахтай холбогдсон үйл ажиллагааг Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас баталсан журмаар зохицуулна. Уг үйлчилгээний хөлсний хэмжээг Сангийн сайд тогтооно.;

г/13. Алт олборлогч аж ахуйн нэгж нь алт олборлолтын тухайн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор, Улсын эрдэнэсийн сангаас үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авсан хэрэглэгч нь тэдгээрийн зарцуулалтын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор тус тус Сангийн хямаанд гарган өгч байна. Үнэт металл, эрдэнийн чулуунд зарцуулалтын тайланг ирүүлээгүй байгууллагад үнэт металл, эрдэнийн чулууг Улсын эрдэнэсийн сангаас нэмж олгохыг хориглоно. Тайлан гаргах журмыг Сангийн яам батална.;

д/14 дүгээр зүйлийн "а" заалт. "а/аж ахуйн нэгж, байгууллагын үнэт металаар хийсэн бүтээгдэхүүний сорьцэнэ дүрмийн 8 дугаар зүйлд заасан хэмжээ болон түүнд нийцүүлэн гаргасан улсын стандартын шаардлагад тохирч байгаа эсэх.;"

е/16 дугаар зүйлийн "б" заалт. "б/ сорьцны хяналт хийхтэй холбогдсон Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн, зөрчлийг арилгах талаар өгсөн шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтан, иргэдийг " Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай"

Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлийн 2-ын 5-д заасны дагуу улсын байцаагч 15000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгох;"

2. Тус дүрмийн 14 дүгээр зүйлийн "г" заалтаас"... хадгалалт, хамгаалалт" гэснийг хассугай.

3. Тус дүрмийн 1,7,8,19 дүгээр зүйлүүдэд "БНМАУ" гэснийг "Монгол Улс" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын дарга
Сангийн сайд

П.ЖАСРАЙ
Ч.УЛААН
Э.БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Хөдөлмөрийн хөлсний жишиг
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 37 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн улсын үйлдвэрийн газрын даргын болон төрийн өмч давамгайлсан хувьцаат компанийн ерөнхий захирлын албан тушаалын сарын хөдөлмөрийн хөлсний жишгийг Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 9 дахиннаас илүүгүй байхаар бодож удирдаж буй нэгжийнх нь үйл ажиллагааны цар хүрээ, үр дүнг харгалзан гэрээ дүгнэх үедээ тогтоож байхыг харьяалах сайд, тусгай газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

2. Улсын үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан хувьцаат компанид ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний тогтолцоог бүрдүүлэхэд баримтлах нийтлэг журмыг хавсралтын ёсоор баталсугай.

3. Улсын үйлдвэрийн газарт болон төрийн өмч давамгайлсан хувьцаат компанид хөдөлмөрийн хөлсний тогтолцоог бүрдүүлэх нийтлэг журмыг үндэслэн хөдөлмөрийн хөлсний талаар журам гаргаж мөрдүүлэхийг улсын үйлдвэрийн газрын дарга, төрийн өмч давамгайлсан хувьцаат компанийн ерөнхий захирал нарт зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд
Сангийн сайд

П.ЖАСРАЙ
Э.ГОМБОЖАВ
Э.БЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 90 дүгээр
тогтоолын хавсралт

**УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР БОЛОН ТӨРИЙН ӨМЧ
ДАВАМГАЙЛСАН ХУВЬЦААТ КОМПАНИД АЖИЛЛАГЧ-
ДЫН ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮ-
ЛЭХЭД БАРИМТЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

Улсын үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан хувьцаат компани (цаашид "аж ахуйн нэгж" гэх) ажилтнуудынхаа хөдөлмөрийн хөлсний тогтолцоог бүрдүүлэх, тэдний хөдөлмөрийн хөлсийг хийсэн ажлынх нь үр дүнд тохируулан олгоход энэхүү журмыг баримтлана.

Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд заасан зарчмуудыг үндэс болгон ажилтны хөдөлмөрийн хөлсийг тэдний гүйцэтгэж буй ажлын түвэгшил, онцлог шинж чанар, хариуцлагын түвшин, үрдүн, ажилтны ажлын дадлага туршлага, мэдлэг мэргэшлийн өсөлт болон хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлтөөс хамааруулан тогтоож тухайн аж ахуйн нэгжийн санхүү-эдийн засгийн бололцоо, үр ашгийн байдалтай уялдаатайгаар ажилтны хөдөлмөрийг шударгаар үнэлэхүйц хөдөлмөрийн хөлсний тогтолцоог бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

I. Аж ахуйн нэгж нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан "Мэргэжил, албан тушаалын нэрийн нэгдсэн жагсаалт"-д нийцүүлэн мэргэжил, албан тушаалын нэрийг шинэчлэн тогтоож, "Тариф мэргэшлийн лавлах

зохиох аргачилсан заавар"-ын дагуу ажиллагчдын тариф мэргэшлийн лавлах, албан тушаалын заавар гаргаж мөрдөнө.

Тариф мэргэшлийн лавлах, албан тушаалын заавар нь ажилтнуудын хөдөлмөрийн хөлсийг албан тушаал, ажлын хариуцлага, түвэгшил, хөдөлмөрийн нөхцөлөөр илгавартай тогтоох үндэслэл болно.

2. Аж ахуйн нэгж нь Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэн дотоод нэгждээ мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хөрөнгийн боломж, үйлдвэрлэлийн үр ашгийн үзүүлэлтүүдийн түвшинг харгалзан тогтооно.

3. Аж ахуйн нэгжид мөрдөхөөр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь тухайн аж ахуйн нэгжийн эргийн хөдөлмөр эрхэлдэг ажилтан (үйлчлэгч болон 1 дүгээр зэргийн ажилчин гэх мэт)-ы хөдөлмөрийн үндсэн хөлсний хэмжээ болно.

4. Аж ахуйн нэгжид мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон Засгийн газраас тогтоосон удирдлагын хөдөлмөрийн хөлсний жишгийг үндэслэн нийт ажилтнуудын хөдөлмөрийн үндсэн хөлсийг тэдний албан тушаал, гүйцэтгэх ажлын хариуцлага, түвэгшлээс хамааруулан илгавартай тогтооно.

5. Ижил албан тушаалын ажил гүйцэтгэж буй ажилтны хөдөлмөрийн үндсэн хөлс адил байна. Харин тэдний хөдөлмөрийн хөлс нь тухайн ажилтны ажилласан хугацаа, ажлын дадлага туршлага, ажил гүйцэтгэх чадвар, ажлын чанар, үр дүнгээс хамааран илгавартай байж болно.

6. Үйлдвэрлэл, үйлчилгээг шууд гардан явуулдаг ажилчдын хөдөлмөрийн хөлсний сүлжээг тариф мэргэшлийн лавлахын дагуу боловсруулахдаа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний технологийн онцлог шинж чанараас хамааруулан тарифын зэргийн тоог тогтооно.

7. Тарифын зэрэг нь ажлын түвэгшлийн хэмжээг илэрхийлсэн тарифын коэффициенттой байна. Тарифын коэффициент нь зэрэг хоорондын хөдөлмөрийн хөлсний илгавар харуулна.

8. Тарифын зэрэг, коэффициентыг үндэслэн ажилчдын нэг цагт гүйцэтгэх хөдөлмөрийн хөлсний хэмжээг илэрхийлсэн хөдөлмөрийн хөлсний сүлжээг боловсруулна.

9. Ажилчдын тухайн ээлжинд болон ажлын өдөр, цагт гүйцэтгэх ажлын хэмжээ (хөдөлмөрийн норм, норматив)-г тэдний ажиллаж буй суурь машин, техникийн хүчин чадлыг үндэслэн тогтоож болно.

10. Удирдах болон захиргааны гүйцэтгэх, туслах албан тушаалтан, ажлыг нь нормчлох боломжгүй бусад ажилтны

хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцож, эл журмын 3,4 дүгээр зүйлд заасны дагуу тогтооно.

11. Ажилтнуудад хөдөлмөрийн үндсэн хөлснөөс гадна Хөдөлмөрийн хуульд заасны дагуу төрөл бүрийн нэмэгдэл хөлсийг хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тусган эдгээр гэрээний хэрэгжилтийн явц, түүний үр дүнг харгалзан олгож байна.

12. Ажилтанд сард олгох нэмэгдэл хөлсний нийт хэмжээ нь хэрэв хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тухайн ажилтны сарын хөдөлмөрийн хөлсний 40 хувиас илүүгүй байвал зохино.

13. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүн, хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс хамааруулан ажилтнуудад шагнал урамшил олгоно.

14. Аж ахуйн нэгжийн цэвэр ашгийн болон хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй холбоон хөдөлмөрийн хөлсийг нэмж болно. Тэгэхдээ энэхүү өсөлтийн хувь нь цэвэр ашгийн өсөлтийн хувиас түрүүлэхгүй байна.

15. Аж ахуйн нэгжид мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон сүлжээг Засгийн газраас тогтоох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн тогтоож болно.

16. Улсын үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан хувьцаат компани нь энэхүү нийтлэг журмыг үндэслэн хөдөлмөрийн хөлсний талаар журам гаргаж дотооддоо мөрдөнө.

17. Энэхүү журмыг бусад компани, хоршоо, хувиараа эрхлэх аж ахуй ажилтныгаа хөдөлмөрийн хөлсний тогтолцоог бүрдүүлэхэд ашиглаж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 охи 6 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Зарим сургуулийг нэрэмжит
болгох тухай

Соблын яам, Өвөрхангай, Увс аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын төрийн зүтгэлтэн, Сайн ноён хан Т.Намнансүрэн, алдарт туульч М.Парчин нарын дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор Өвөрхангай аймгийн Уянга сумын 10 жилийн дунд сургуулийг Т.Намнансүрэнгийн, Увс аймгийн Хяргас сумын 10 жилийн дунд сургуулийг М.Парчингийн нэрэмжит тус тус болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Соёлын сайд

П.ЖАСРАЙ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

Гурилд ногдуулах гаалийн албан
татварыг хөнгөлөх тухай

Монгол Улсын Гаалийн хуулийн 15 дугаар зүйлийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-алтай, Завхан аймгуудын хөдөлмөрчдийн хэрэгцээнд зориулан тэдгээр аймгуудын дэвсгэр нутаг дахь хилийн боомтоор гурид оруулсан импортлогчийн тухайн бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн албан татварыг энэ оны 11 дүгээр сарын 01 хүртэл хугацаанд 100 хувиар хөнгөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд
Сангийн сайд

П.ЖАСРАЙ
Э.БЯМБАЖАВ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 6 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны болон төрийн
үйлчилгээний албаны албан
тушаалын ангилал, зэрэглэлийг
тогтоох тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт болон 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг 1 дүгээр хавсралтын, төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг 2,3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолоор баталсан албан тушаалын ангилал, зэрэглэлд ийцүүлэн албан хаагчдынхаа албан тушаалыг шинэчлэн тогтоож өөрдүүлэхийг сайд, тусгай газрын дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эрх баригчдад тавгасугай.

3. Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлийн ТЗ-9-д дүүргийн Засаг даргын, ТЗ-8-д сумын Засаг даргын, ТЗ-5-д хорооны Засаг даргын, ТЗ-4-д багийн Засаг даргын албан тушаалыг тус тус хамааруулах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Энэ тогтоолоор батлагдсан албан тушаалын ангилал, зэрэглэлд өрсөгүй буюу шинээр бий болсон албан тушаалын ангилал, зэрэглэлийг холбогдох яам, газрын саналыг үндэслэн Сангийн нэмтэй зөвшилцөн тогтоож байхыг Хүн амын бодлого, төдөлмөрийн нэмэнд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд

**П.ЖАСРАЙ
Э.ГОМБОЖАВ**

Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны
 албан тушаалын ангилал, хэрэглээ

Төрийн захиргаа	Төрийн захиргаа			Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр
	1	2	3	
Төрийн захиргаа	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр
ТЭР- ГҮҮН	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	ТЭ-13	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр
ТҮШ- МЭМ	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	ТЭ-12	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр
ЭР, ХХЗ, СЭН	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	ТЭ-11	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр
ТЭШ, МЭМ	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр	ТЭ-10	Төрийн захиргаагийн албан тушаалын бүлэг, нэр

A	1	2	3	4	5
AM- LAK	Якшы кытчы, Ташкын даягы, Алла багынчы, Алла	Бодушка ады Кызылбардык Чымык, алаш Ташкын Бодушкадан ады	ТЗ-9	1. Бакшы кытчыны даягы 2. Якшы кытчы уюлду бугула орады түрдөй кытчы кытчыны даягы 3. Якшы кытчы даягы бугула орады жерин кытчы даягы 4. Якшы кытчы уюлду бугула даягы бугула орады Бодушкадан ады кытчы кытчы акырагыны Бодушкадан ады 5. Түрдөй Бодушкадан ады кытчы кытчы акырагыны, Алла жашын, Чымык, Алла аманакташын орады же түрдөй кытчы кытчыдан ады түрдөй түрдөй бугула Бодушкадан ады 6. Мышык башын кытчыны даягы	1. Нокытанын Якшы даягы Ташкын кытчы кытчыны даягы 2. Уюлду бугула кытчы Акырагыны алаш адыны кытчыны даягы 3. Нокытанын Якшы даягы даягыны кытчы кытчыны даягы 4. Түрдөй Якшы даягы орады
ТШ- MCH	Якшы кытчы, Ташкын даягы, Алла багынчы, Алла Кызылбардык, Ташкын Акырагы ады Ташкын	Бодушка ады Кызылбардык Чымык, алаш Ташкын Бодушкадан ады	ТЗ-1	1. Бакшы кытчыны даягы 2. Якшы кытчы уюлду бугула орады түрдөй кытчы кытчыны даягы 3. Якшы кытчы даягы бугула орады жерин кытчыны даягы 4. Якшы кытчы уюлду бугула даягы бугула орады Бодушкадан ады кытчы кытчы акырагыны Бодушкадан ады даягы	1. Нокытанын Якшы даягы Ташкын кытчы кытчыны даягы 2. Уюлду бугула кытчы Акырагыны алаш адыны кытчыны даягы 3. Нокытанын Якшы даягы даягыны кытчы кытчыны даягы 4. Түрдөй Якшы даягы Ташкын кытчы кытчыны даягы 5. Акырагы Якшы даягы даягыны кытчы кытчыны даягы 6. Түрдөй Якшы даягы Ташкын кытчы даягы 7. Түрдөй Ташкын Ташкын кытчыны даягы Ташкын кытчыны башын даягы 8. Чымык Якшы даягы орады
			ТЗ-7	1. Бакшы алаш багынчы, алаш акырагыны 2. Якшы кытчы уюлду бугула орады түрдөй кытчы алаш багынчы, алаш акырагыны 3. Якшы кытчы даягы бугула орады жерин кытчыны даягы 4. Якшы кытчы уюлду бугула даягы бугула орады Бодушкадан ады кытчы кытчы акырагыны Бодушкадан адыны даягы 5. Мышык башын алаш багынчы, алаш акырагыны 6. Уюлду алаш багынчы	1. Нокытанын Якшы даягы Ташкын кытчы кытчыны даягы 2. Уюлду бугула кытчы Акырагыны алаш адыны кытчыны даягы 3. Нокытанын Якшы даягы даягыны кытчы кытчыны даягы 4. Түрдөй Якшы даягы Ташкын кытчы кытчыны даягы 5. Акырагы Якшы даягы даягыны кытчы кытчыны даягы 6. Түрдөй Якшы даягы Ташкын кытчы даягы 7. Түрдөй Ташкын Ташкын кытчыны даягы Ташкын кытчыны башын даягы 8. Чымык Якшы даягы орады

A	1	2	3	4	5
		<p>Мурғашын Батыс, тушарына тушарына болушы таспа болушы таспа болушы таспа күрөңгүлү күрөңгүлү сүлөк, акыл сүлөк, Бодатын күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	Т3-5	<p>1. Акыл байлап, корголоту 2. Акыл сүлөк түстөй бүткүл өрдөк түстөй түрөй байлап, корголоту 3. Акыл сүлөк дээ бүткүл өрдөк түрөй акыл байлап, акыл корголоту 4. Акыл сүлөк түстөй болуп дээ бүткүл өрдөк бүткүлүлүкү өрдөк түрөй акыл корголоту 5. Акыл сүлөк байлап, корголоту 6. Акыл сүлөк</p>	<p>1. Индикатори дээр дээр Төмөр түрөй акыл байлап, акыл корголоту 2. Уламбайр үчкө Заманачын акыл акыл байлап, акыл корголоту 3. Индикатори дээр дээр дээр дээр акыл байлап, акыл корголоту 4. Дурдун дээр дээр Төмөр түрөй болуп дээр дээр дээр халтын дээр 5. Акыл дээр дээр Төмөр түрөй түстөй дээр 6. Сүмө дээр дээр Төмөр түрөй дээр 7. Сүмө Индикатори Төмөрүлүкү Түрүлүкүлү түрөй болуп дээр</p>
ДЭС				<p>1. Салын бую түстөй бүткүл өрдөк түстөй түрөй дээр түстөй 2. Акыл сүлөк дээ бүткүл өрдөк түрөй байлап, корголоту 3. Акыл сүлөк түстөй болуп дээ бүткүл өрдөк бүткүлүлүкү өрдөк түрөй акыл корголоту 4. Акыл сүлөк түстөй болуп, акыл корголоту</p>	<p>1. Индикатори дээр дээр Төмөр түрөй байлап, корголоту 2. Уламбайр үчкө Заманачын акыл акыл байлап, корголоту 3. Индикатори дээр дээр дээр дээр акыл байлап, корголоту 4. Акыл дээр дээр Төмөр түрөй болуп, дээр дээр дээр болуп индикатори акыл акыл байлап, акыл корголоту 5. Дурдун дээр дээр Төмөр түрөй түстөй дээр</p>
ТШ- МЭЛ		<p>Түстөк түстөй күрөңгүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	Т3-4	<p>1. Акыл сүлөк түстөй болуп дээ бүткүл өрдөк түстөй 2. Акыл сүлөк түстөй болуп дээ бүткүл өрдөк бүткүлүлүкү өрдөк түрөй акыл корголоту</p>	<p>1. Акыл дээр дээр Төмөр түрөй болуп, дээр дээр дээр болуп индикатори акыл акыл байлап, корголоту 2. Дурдун дээр дээр Төмөр түрөй акыл байлап, акыл корголоту 3. Сүмө дээр дээр Төмөр түрөй түстөй дээр</p>
ТУС- ДАК	<p>Акыл түстөй түстөй түстөй күрөңгүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	<p>Батыс Батыс күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	Т3-3	<p>1. Акыл сүлөк түстөй болуп дээ бүткүл өрдөк бүткүлүлүкү түстөй байлап, түстөй корголоту</p>	<p>1. Индикатори дээр дээр Төмөр түрөй түстөй байлап, түстөй корголоту 2. Уламбайр үчкө Заманачын акыл акыл түстөй байлап, түстөй корголоту 3. Индикатори дээр дээр дээр дээр түстөй байлап, түстөй корголоту 4. Сүм, дурдун дээр дээр Төмөр түрөй болуп дээр дээр дээр акыл акыл байлап, корголоту</p>
ТШ- МЭЛ	<p>Акыл түстөй түстөй түстөй күрөңгүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	<p>Акыл күрөңгүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	Т3-2	<p>1. Акыл дээр дээр Төмөр түрөй болуп дээр дээр дээр акыл акыл түстөй байлап, түстөй корголоту 2. Акыл, индикатори дээр дээр түстөй 3. Акыл, индикатори</p>	<p>1. Акыл дээр дээр Төмөр түрөй болуп дээр дээр дээр акыл акыл түстөй байлап, түстөй корголоту 2. Акыл, индикатори дээр дээр түстөй 3. Акыл, индикатори</p>
ТШ- МЭЛ	<p>Акыл түстөй түстөй түстөй күрөңгүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	<p>Акыл күрөңгүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү күрөңгүлүлү</p>	Т3-1	<p>1. Сүм, дурдун дээр дээр Төмөр түрөй болуп дээр дээр дээр акыл акыл түстөй байлап, түстөй корголоту 2. Акыл, индикатори</p>	<p>1. Сүм, дурдун дээр дээр Төмөр түрөй болуп дээр дээр дээр акыл акыл түстөй байлап, түстөй корголоту 2. Акыл, индикатори</p>

Засгийн газрын 1995 оны 94 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН АЛБАН ТУШААЛЫН
АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЭ

N	* Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд ханаарах албан тушаалын төвч тодорхойлолт	Албан тушаалын зэрэглэл
Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргадаг буюу байгууллагын эрх захиралчийг албан ёсоор орлох эрх бүхий албан тушаал	ТҮ-14 ТҮ-13 ТҮ-12 ТҮ-11 ТҮ-10 ТҮ-9 ТҮ-8	
Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авьяас ур чадвар, туршлага шаардагдах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээр бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮ-7 ТҮ-6 ТҮ-5	
Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮ-4 ТҮ-3 ТҮ-2	
Бага тушаалын албан хаагч	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай, мэргэжил, боловсрол үл шаардах үйлчилгээний ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮ-1	

11-6	1	2	3	4	5	6	7	8	9	10
11-7	1	2	3	4	5	6	7	8	9	10
11-6	1	2	3	4	5	6	7	8	9	10
11-7	1	2	3	4	5	6	7	8	9	10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-6
1
2
3
4
5
6
7
8
9
10

11-7
1
2
3
4
5
6
7
8
9
10

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 6 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 95

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны болон төрийн
үйлчилгээний албаны албан хааг-
чийн албан тушаалын цалингийн
сүлжээг батлах тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зөвсөнг болон хөрөнгийн эх үүсвэртэй холбогдуулан 1995 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах талаар Засгийн газраас оруулсан саналыг Улсын Их Хурал чуулганы хуралдаанаараа хэлэлцээд өгсөн чиглэлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын, төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус мөрдүүлсүгэй.

3. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг сэрэглэхдээ Засгийн газраас баталсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг баримталж байхаар тогтоосугай.

4. Сайд, тусгай газрын дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эрх баригч нарт даалгах нь:

а) төрийн захиргааны албан хаагч албан тушаал дэвших тохиолдолд тухайн үед авч байсан цалингийн хэмжээнээс нь бууруулахгүйгээр албан тушаалын цалинг нь тогтоож байсугай;

б) төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн ажлыг үнэлж дүгнэсний үндсэн дээр тэдний цалинг батлагдсан цалингийн сандаа багтаан албан тушаалын цалингийн сүлжээний дагуу нэмэгдүүлэх асуудлыг ажлынх нь

үр дүнтэй холбоо шийдвэрлэж байх журам боловсруулж цаашид мөрдөж ажилласугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

Сангийн сайд

Э. БЯМБАЖАВ

Төрийн газрын 1955 оны 85 дугаар
 тогтоомын 1 дүгээр хэсгээр

Төрийн захиргааны албан хаагчийн
 албан тусгааны цалингүйн сүүх

(сая-төгөрөөр)

Төрийн тусгай албан тусгай зэрэг- лэн бүтээх (милээр)	Албан тусгааны зардал												
	T2-1	T2-2	T2-3	T2-4	T2-5	T2-6	T2-7	T2-8	T2-9	T2-10	T2-11	T2-12	T2-13
1	13000	14000	15000	16000	17000	18100	19200	20400	21700	23100	24600	26200	28000
2	13250	14250	15300	16300	17350	18450	19600	20800	22100	23550	25050	26700	28500
3	13500	14500	15650	16650	17750	18850	20050	21250	22550	24050	25550	27250	29050
4	13900	14900	16050	17050	18200	19300	20550	21750	23050	24600	26100	27850	29650
5	14250	15200	16450	17500	18650	19800	21050	22300	23600	25000	26500	28100	30000
6	14600	15650	16850	17900	19100	20250	21550	22800	24150	25750	27300	28900	30650
7	14900	16000	17200	18300	19500	20700	22000	23300	24650	26300	27950	29700	31550
8	15200	16300	17550	18650	19900	21100	22450	23800	25150	26800	28400	30250	32150
9	15500	16600	17900	19000	20300	21500	22900	24250	25650	27300	28900	30800	32700
10	15800	16900	18200	19300	20700	21900	23300	24700	26100	27750	29400	31300	33250
11	16200	17300	18600	19700	21100	22300	23700	25100	26550	28200	29900	31800	33800
12	16500	17600	18900	19900	21400	22700	24100	25500	27000	28650	30400	32300	34300
13	16850	17950	19200	20200	21700	23050	24500	25900	27400	29100	30850	32800	-
14	16800	18000	19400	20500	22150	23400	24850	26300	27800	29500	31300	33300	-
15	17000	18250	19700	20800	22500	23750	25200	26700	28200	29900	31750	-	-
16	17200	18500	19900	21100	22300	24100	25550	27050	28600	30300	32200	-	-
17	17400	18750	20200	21400	23100	24400	25900	27400	29000	30700	-	-	-
18	17600	19000	20450	21700	23400	24700	26200	27750	29350	31100	-	-	-
19	17800	19200	20700	22000	23700	25000	26500	28100	29700	-	-	-	-
20	18000	19400	20950	22250	23950	25300	26800	28400	30000	-	-	-	-
21	-	19600	21200	22500	24200	25550	27100	-	-	-	-	-	-
22	-	19800	21400	22750	24450	25800	27400	-	-	-	-	-	-
23	-	-	21600	23000	24700	26050	-	-	-	-	-	-	-
24	-	-	-	23200	24900	26300	-	-	-	-	-	-	-
25	-	-	-	23400	25100	26500	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1995 оны 95 дугаар
тогтоолын 2 дугаар хэсгээр

Төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн
албан тухааны цалингийн сүлээ

(сая-төгвөгөөр)

Төрийн тухайн албан тухаан эрхэл- сэн хугацаа (жишээр)	Албан тухааны зардалт													
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14
1-2	9600	10800	12000	13250	14500	15750	17000	18250	19500	20850	22200	25050	28000	31500
3-4	9900	11100	12300	13550	14800	16050	17300	18550	19800	21250	23200	26050	29000	33000
5-6	10300	11500	12700	13950	15200	16450	17700	18950	20200	21750	23800	27050	30000	34500
7-8	10700	11900	13100	14310	15600	16850	18100	19350	20600	22350	24400	28050	31000	36000
9-10	11200	12400	13600	14850	16100	17350	18600	19850	21100	22950	25100	29150	32100	-
11-12	11700	12900	14100	15350	16600	17850	19100	20350	21600	23550	25800	30250	33200	-
13-14	12200	13400	14600	15850	17100	18350	19600	20850	22100	24150	26400	31350	34300	-
15-16	12700	13900	15100	16350	17600	18850	20100	21350	22600	24650	26900	-	-	-
17-18	13100	14300	15500	16750	18000	19250	20500	21750	23000	25050	-	-	-	-
19-20	13500	14700	15900	17150	18400	19650	20900	22150	23400	-	-	-	-	-
21	13800	15000	16200	17450	18700	19950	21200	22450	23700	-	-	-	-	-

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ**

1995 оны 8 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 246

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ХУУЛИЙН 7-Р ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ
ТАЙЛВАРЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 7-р зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан "Анхдагч түүхий эд-мах, сүү, үр тариа, түүнчлэн гурилми үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлөх татвар төлөгчид гэрээ дүрэмдээ заасны дагуу мах, сүү, үр тариа болон гурилми үйлдвэрлэл тогтмол эрхлэн, хүнсний анхдагч байдлаар нь зах зээлд борлуулж байгаа хүнс, хөдөө аж ахуйн нөхөрлөл, компани, хоршоо зэрэг хуулийн этгээдийн эрхтэй аж ахуйн нэгж, байгууллагыг хамааруулан ойлгохыг тайлбарласугай.

Харин дээрх дурдсан хүнсний анхдагч түүхий эдийг боловсруулж бэлэн болон хагас бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж орлого олж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг энэ заалтад хамааруулж татварыг нь хөнгөлөхгүйг заасугай.

Ерөнхий шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч

А. ДОРЖГОТОВ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч	Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сэн. Жаргалсайхан
Гишүүд	Т. Бавсансүрэн Ч. Бавуу Б. Ганбат Б. Янжинлхам
Техник редактор	Т. Сарантуяа
Ушиж хянасан	Сэн. Жаргалсайхан Б. Янжинлхам
Үйлдвэрт шилжүүлсэн	1995 оны 11-р сарын 14-нд.
Өрөлтөд	1995 оны 11-р сарын 14-нд.
Хэвлэлтэд	1995 оны 12-р сарын 18-нд.
Хэвлэлийн хуудас	6,0. Хэвлэсэн тоо 4450.

Манай хаяг: Улаанбаатар-12,
Төрийн ордон. Утас: 322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр